



# ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2016





## АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ	7
ХУРААНГУЙ	8
НЭГ. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	10
1.1. Олон улсын санхүүгийн зах зээлийн чиг хандлага	11
1.2. Банкнаас бусад санхүүгийн салбарын өнөөгийн байдал	12
1.2.1. Үнэт цаасны зах зээл	13
1.2.2. Даатгалын зах зээл	19
1.2.3. Банк бус санхүүгийн байгууллага	24
1.2.4. Хадгаламж, зээлийн хоршоо	29
ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ	35
2.1. Бодлого, зохицуулалт	36
2.2. Бүртгэл, зөвшөөрөл	39
2.3. Хяналт шалгалт	41
ГУРАВ. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ДЭМЖИХ	43
3.1. Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх	44
3.1.1. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх	44
3.1.2. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах	45
3.2. Салбарын эрх зүйн орчин, түүнийг боловсронгуй болгох	49
ДӨРӨВ. ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА	50
4.1. Бүтэц, зохион байгуулалт	51
4.2. Дотоод үйл ажиллагаа	52
4.3. Хамтын ажиллагаа	53
4.4. Төсөв, санхүү	55
ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУД	56

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТТ	Арилжааны төлбөр тооцоо
АХБ	Азийн хөгжлийн банк
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрлэл
ЗГ	Засгийн газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МББСБХ	Монголын Банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо
МИК	Монголын ипотекийн корпораци
МУЦАЭХ	Монголын Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо
МХЗХҮХ	Монголын Хадгаламж, зээлийн хоршоодын Үндэсний холбоо
НББ	Нягтлан бодох бүртгэл
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
ОССК	Орон сууцны санхүүжилтийн корпораци
ОУВС	Олон улсын валютын сан
Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦК	Үнэт цаасны компани
ҮЦТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ҮЦТХТ	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
ХААБ	Хөдөө аж ахуйн бирж
ХЗХ	Хадгаламж, зээлийн хоршоо
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭЗБХ	Эдийн засгийн байнгын хороо

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/	13
Зураг 2. Зах зээлийн үнэлгээ ба Дотоодын нийт бүтээгдэхүүн	14
Зураг 3. Хувьцаат компанийн тоо	15
Зураг 4. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/	17
Зураг 5. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ /хувь/	18
Зураг 6. Даатгалын нэвтрэлт, нягтрал	19
Зураг 7. Компаниудын нийт хөрөнгө, хөрөнгийн өсөлт	20
Зураг 8. Даатгалын нийт хураамжийн орлого, давхар даатгалын хураамж	21
Зураг 9. Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт	22
Зураг 10. Даатгалын нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/	22
Зураг 11. Тайлант хугацааны цэвэр ашиг /тэрбум төгрөг/	23
Зураг 12. Даатгалын нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр	23
Зураг 13. ББСБ–уудын тооны өөрчлөлт	24
Зураг 14. Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/	26
Зураг 15. Салбарын ангиллаар олгосон зээл /оны эхнээс өссөн дүнгээр/	27
Зураг 16. Зээлийн жигнэсэн дундаж хүү	27
Зураг 17. Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/	29
Зураг 18. ХЗХ–дын тооны өөрчлөлт	30
Зураг 19. ХЗХ–дын тоо /байршлаар/	30
Зураг 20. ХЗХ–дын гишүүдийн тооны өөрчлөлт	31
Зураг 21. Салбарын хэмжээгээр нийт активын өсөлт	32
Зураг 22. Зээлийн багцын өөрчлөлтийг харьцуулж харуулбал	33
Зураг 23. Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлт	33
Зураг 24. Ашигт ажиллагаа	34
Зураг 25. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /салбар тус бүрээр/	46
Зураг 26. Үнэт цаасны өргөдөл, гомдол /төрлөөр/	46
Зураг 27. Даатгалын өргөдөл, гомдол /төрлөөр/	47
Зураг 28. ББСБ–ын өргөдөл, гомдол /төрлөөр/	48
Зураг 29. ХЗХ–ны өргөдөл, гомдлыг /төрлөөр/	48
Зураг 30. Бүтэц	51

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо	15
Хүснэгт 2. Арилжааны үзүүлэлт	16
Хүснэгт 3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/	17
Хүснэгт 4. Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо	20
Хүснэгт 5. Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/	21
Хүснэгт 6. Үндсэн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/	25
Хүснэгт 7. Активын бүтэц	26
Хүснэгт 8. Өр төлбөр ба эздийн өмч	28
Хүснэгт 9. Үндсэн үзүүлэлтүүд	32
Хүснэгт 10. Зөвшөөрөл, эрхийн тоо /Үнэт цаас/	39
Хүснэгт 11. Зөвшөөрөл, эрхийн тоо /Даатгал/	39
Хүснэгт 12. Зөвшөөрөл, эрхийн тоо /ББСБ/	40
Хүснэгт 13. Зөвшөөрөл, эрхийн тоо /ХЗХ/	40
Хүснэгт 14. Баримт бичгийн эргэлтийн мэдээ	53
Хүснэгт 15. Төсвийн орлого ба зарлага /сая төгрөгөөр/	55



## ӨМНӨХ ҮГ

2016 он Монгол Улсын эдийн засагт сорилт бэрхшээл тулгарсан хүндхэн жил болж өнгөрлөө. Засаглалын хямралт, үрэлгэн байдлаас үүдэж гадаадын хөрөнгө оруулагчдын итгэл, дэлхийн зах зээл дээрх эрдэс, түүхий эдийн үнийн уналтаар үргэлжилсэн хүндрэлийн үр урхаг ард иргэдийн амьдралд тод мэдрэгдсэн жил болов. Улсын өрийн түвшин тооцоолсноос хэтэрч, төлбөрийн хугацаа тулсны дээр зээлжих зэрэглэл буурч гадаадын бодит хөрөнгө оруулалтыг хязгаарласан нь манай эдийн засагт улам дарамт болж байлаа.

Нийгэм, эдийн засгийн энэхүү гарцаагүй агаад зайлшгүй шаардлагын улмаас Санхүүгийн зохицуулах хороо (Хороо) бодлого, үйл ажиллагаандаа томоохон өөрчлөлт оруулж, бүртгэл зөвшөөрөл, хяналтын байгууллагаас санхүүгийн салбарт бодлогын зохицуулалт хийж, хөгжүүлдэг, эрсдэлийг бууруулж, эрх ашгийг хамгаалдаг институци болох ойрын болон дунд хугацааны стратеги зорилгоо тодорхойлж, зорилтуудаа төлөвлөлөө. Эдгээр зорилтдоо хүрэхийн тулд хөрөнгийн зах зээл, төлбөр тооцооны дэд бүтцийн шинэчлэлийг эрчимжүүлэх, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох, банкнаас бусад санхүүгийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг олшруулах, өрсөлдөх чадварыг сайжруулж, харилцагч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн болон хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх арга хэмжээг шат дараатай, харилцан уялдаатай авахаар төлөвлөж эхлэлийг тавилаа.

Манай санхүүгийн тогтолцоо өнөөдөр банк хэмээх ганц тулгуур дээр тогтож байна. Хүндрэл бэрхшээлийг даван туулах, системийн эрсдэлээс сэрэмжлэхийн тулд банкнаас бусад санхүүгийн байгууллагуудаа одоо байгаагаас нь илүү чадавхжуулах үүднээс мөчлөг сөрсөн бодлогыг хэрэгжүүллээ. Хөрөнгө, санхүүгийн удирдлагын бизнесийг сайн дурын, дур зоргын төлөвөөс шат ахиулж, судалгаа шинжилгээнд суурилсан мэргэжлийн үйл ажиллагаа болгон хөгжүүлэх нь оролцогчдын төдийгүй үйлчлүүлэгчдийн эрх ашигт нийцнэ.

Хөгжлийн бодлого стратеги, хэт, ойрын зорилго, зорилтоо амжилттай хэрэгжүүлэх үүднээс Хорооны эрх зүйн байдлын тухай болон салбарын хуулиудыг шинэчлэн сайжруулахаар ажиллаж байна. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, зохицуулалтын үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэх, зах зээлийн тогтвортой хөгжлийн нөхцөлийг бүрдүүлэхэд хүч, анхаарлаа хандуулна.

Хийсэн ажил, хэрэгжүүлсэн бодлогын үр дүн, хэтийн зорилтуудаа хойно дэлгэрэнгүй дурдах тул үл нурушин, эрхэм Танд Хорооны 2016 оны үйл ажиллагааны тайланг өргөн барьж байна.

Таны санал, шүүмж бидэнд нэн үнэ цэнэтэй байх болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ДАРГА  С.ДАВААСҮРЭН

## ХУРААНГУЙ

Дэлхийн худалдааны эргэлт муудаж, хөрөнгө оруулалт бууран, бодлого зохицуулалтын тодорхой бус байдал үүссэн нь улс орнуудын эдийн засагт нөлөөлсөн жил байлаа. Гэсэн хэдий ч олон улсын санхүүгийн оролцогч болон зохицуулагч байгууллагууд эдийн засгийн хүндрэлийг бага зардлаар даван туулах төсөл, хөтөлбөр боловсруулан богино, дунд хугацаанд сэргээх стратегиудыг Засгийн газар (ЗГ)–тайгаа хамтран хэрэгжүүлж эхэлсэн.

Монгол Улсын макро эдийн засаг 2016 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт буурсан, валютын ханш өссөн, эдийн засгийн өсөлт саарсан, ашигт малтмал, түүхий эдийн үнэ буурч хүндхэн жилийг даван тууллаа.

Банкнаас бусад санхүүгийн зах зээл 2016 онд 2.6 их наяд төгрөгт хүрч, дунджаар 20 хувиар өссөн ба уг өсөлтөд төрийн дэмжлэг, бодлого зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт голчлон нөлөөлсөн. ДНБ–д эзлэх банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хэмжээ 10.9 хувь ба 2015 оны түвшнээс 1.7 хувиар нэмэгджээ. Зарим салбарын хувьд тоон үзүүлэлтүүд өссөн ч чанарын өөрчлөлт гарахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь нийгэм эдийн засгийн өөрчлөлт, техник технологийн хурдцаас хамааран салбаруудын хууль, эрх зүйн орчныг тэдгээрт нийцүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны арилжааны хэмжээ 2016 онд өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн байгаа нь манай улсын хөрөнгийн зах зээл дээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх сэргэн, зах зээлийг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх боломж байгааг харууллаа.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дундаж түвшинтэй харьцуулбал доогуур, сүүлийн жилүүдэд өсөлт ажиглагдахгүй байна. Энэ нь иргэдийн санхүүгийн суурь боловсролыг нэмэгдүүлэх, даатгалын хүртээмжийг сайжруулах, даатгалын шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгох орон зай байгааг илэрхийлж байна.

Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)–уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэртэй холбогдуулан ББСБ–уудын нийт актив 2016 оны эцэст 787.2 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2017 оны эцэст 26 хувиар өсөж 992.5 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, салбарт эерэг үр дүн үзүүлнэ гэж үзэж байна.



Хадгаламж зээлийн хоршоо (ХЗХ)–ны салбар үүсч хөгжсөн 20 жилийн ойгоо тохиолдуулан 135 гаруй ХЗХ–ны гишүүд, гадаадын зочид төлөөлөгчид, МХЗХҮХолбоо, Хороо хамтран зохион байгуулсан “Хөгжлийн төлөө хамтдаа” үндэсний хоёрдугаар форумасаа гишүүддээ уриалга гарган эдийн засгийн хүндрэлийг бага зардалтай санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэн хамтдаа даван туулахыг уриалж Дэлхийн болон Азийн ХЗХ–оос суралцан Монголын хөрсөнд тохирсон загвар хоршоод болон идэвхтэй ажиллахаа амласан.

Санхүүгийн үйлчилгээг боломжийн өртгөөр хүргэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний нэгжийн өртгийг бууруулах, шинэ технологийн хэрэглээг бий болгох бодлогыг боловсруулах, тогтвортой, бүрэн, хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох зорилгыг хангах зохицуулалтын бүтцийг бий болгох, бага, дунд орлоготой иргэдэд санхүүгийн салбарын үйлчилгээг хүргэх зорилгоор үйлчлүүлэгчийг хамгаалах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүрж, мэдээлэл цуглуулах, шинжлэх замаар санхүүгийн хүртээмжийн хандлагын өөрчлөлтийг бий болгон бодлогыг боловсруулах нь өнөөгийн даяаршлын чухал зорилт болж байна.

Банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Хороо нь өнөөгийн байдлаар Монгол Улсын 18 хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

Хороо нь холбогдох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд зохицуулалтад хамаарагдах нийт 302 хувьцаат компани, 62 үнэт цаасны компани (ҮЦК), 17 даатгалын компани, 40 даатгалын зуучлагч компани, 31 даатгалын хохирол үнэлэгч компани, 3091 даатгалын төлөөлөгч, даатгалын байгууллагад аудит хийх эрх бүхий 42 аудитын компани, 518 ББСБ болон 280 ХЗХ зэрэг нийт 1324 зохицуулалттай хуулийн этгээдийг санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэн, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор зохицуулалтын салбар чиглэл тус бүрээр тодорхой ажлуудыг хийж байна.

# 1

## САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

## 1.1. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

Дэлхийн худалдааны эргэлт муудаж, хөрөнгө оруулалт бууран, бодлого зохицуулалтын тодорхой бус байдал үүссэн нь эдийн засгийг дарамтад оруулав. 2016 онд дэлхийн эдийн засгийн өсөлт санхүүгийн хямралаас хойш хамгийн доод түвшиндээ буюу 2.3 хувьд хүрэв. Хэдий тийм боловч хөгжиж буй орнуудын эдийн засгийн байдал 2017 онд сэргэх төлөвтэй байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.7 хувь болж өсөхөөр төсөөлөгдөж байна.

Бодлого зохицуулагчдын болон хөрөнгө оруулагчдын шийдвэр хаашаа чиглэх нь тодорхой бус, мөн нийт эдийн засгийн бүтээмжийн өсөлт сул байгаатай холбоотойгоор хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлт удаашралтай, инфляци доогуур түвшинд хэвээр хадгалагдаж, 2016 онд тус орнуудын эдийн засгийн өсөлт 1.6 хувьд хүрэв. Ирэх онд хөгжингүй орнуудын эдийн засаг сайжирч, 1.8 хувьд хүрэхээр хүлээгдэж байна. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)-ын аж үйлдвэрийн салбарт үсрэнгүй дэвшилт гарснаар ирэх 2 жилд эдийн засгийн өсөлтийн түвшин сайжирч 2.2 хувьд хүрэх ажээ. Энэхүү үнэлгээнд бодлого зохицуулалтын нөлөөг оруулагүй бөгөөд сангийн үр ашигтай бодлогыг хэрэгжүүлбэл өсөлтийг дэмжинэ хэмээн үзэж байгаа юм. Харин Евро бус болон Японд инфляцийн түвшин аажмаар өсөх хандлагатай байгаа боловч төв банкны зорилтот түвшнээс доогуур байхаар байна.

2016 онд хөгжиж буй орнуудын эдийн засаг 3.4 хувиар өсөв. Харин 2017 онд 4.2 хувь болж өсөх төлөвтэй байгаа бөгөөд 2013 оноос хойш анх удаа дэлхийн эдийн засгийн өсөлтийн ихэнх хувийг эзлэхээр төсөөлөгдөж байна. Түүхий эдийн үнийн түвшин тогтворжиж, 2017–2019 онд аажмаар өсөх хандлагатай байгаа нь экспортлогч хөгжиж буй орнуудын эдийн засагт дэмжлэг болохоор байна. Өнгөрөгч оны 11 сард АНУ-ын ерөнхийлөгчийн сонгуультай холбоотойгоор хөрөнгийн өгөөж өссөн нь хөгжиж буй орнуудын мөнгөн тэмдэгтийн ханш суларч, хөрөнгө оруулалтын урсгал гадагшилсны улмаас тус орнуудын санхүүгийн зах зээл хумигдахад хүргэв. Энэхүү нөхцөл байдлыг үл тооцвол, хөгжиж буй орнуудын санхүүгийн нөхцөл байдал тогтвортой байгаа юм. Хөгжиж буй орнуудын 2/3 нь газрын тос, метал, хөдөө аж ахуйн бараа, бүтээгдэхүүний экспортоос хамааралтай байдаг. Ихэнх түүхий эдийн үнийн түвшин 2011 оны түвшнээс 40–өөс илүү хувиар унасан нь экспортлогч хөгжиж буй орнуудын худалдааны нөхцөл 4 хувиар, газрын тосны

экспортын хэмжээ 21 хувиар унахад хүргэсэн. Харин хөгжиж буй орнуудын гадны шууд хөрөнгө оруулалт 2000 оны түвшнээс бараг 3 дахин өссөн бөгөөд энэ нь дэлхийн нийт гадны шууд хөрөнгө оруулалтын 1/3-ийг эзэлж байна.<sup>1</sup>

Хөгжингүй орнуудын эдийн засгийн удаашрал, газрын тосны үнийн уналттай холбогдуулан оны эхэнд дэлхийн зах зээлд хүндхэн сорилт тулгарав. Гэвч 2016 онд түүхий эдийн үнэ өсөж, хөгжиж буй орнуудын эдийн засагт эерэг нөлөөг үзүүлэв. Эдийн засгийн өндөр мэдрэмжтэй түүхий эд, аж үйлдвэрийн салбаруудын хувьцааны өгөөж өндөр ногдол ашиг олгодог эрүүл мэнд болон бусад уламжлалт салбаруудын өгөөжийн түвшингээс давж, арилжааны нийт зах зээлд эзлэх хувь хэмжээ нэмэгдэв.

Мөн БНХАУ эдийн засгийн бодлогодоо бүтцийн шинэчлэлт хийж, Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүгээ өсгөхөө мэдэгдсэн нь хувьцааны үнийн түвшинд нөлөөлж, үүний зэрэгцээ 6 дугаар сард Англи улс Европын холбооноос гарах болсноо мэдэгдсэн нь томоохон цохилт болов. Америкийн ерөнхийлөгчийн сонгууль дахь Трампын ялалт болон түүний татварыг бууруулж, хууль эрх зүйн хяналтыг бууруулан, дэд бүтэц болон цэргийн хүчний төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэхээ мэдэгдсэн нь хөрөнгийн зах зээлд өөр нэгэн шокыг үүсгэв.

Дэлхийн ердийн даатгалын хураамжийн орлогын өсөлт өнгөрсөн оноос удаашрав<sup>2</sup>. Өнгөрсөн жилд бодит хураамжийн орлогын өсөлт 3 хувь байсан бол тайлант жил 2.4 хувийн өсөлттэй байв. Хөгжингүй орнуудад эдийн засгийн өсөлт удааширч, арилжааны даатгалын бүтээгдэхүүний үнэ уян хатан тогтож байсантай уялдаж нийт хураамжийн орлогын өсөлт 2.5 хувиас 1.7 хувь болж буурав. Харин хөгжиж буй орнуудын хувьд хураамжийн орлогын өсөлт өнгөрсөн оноос бага хэмжээгээр сайжирч 5.3 хувьд хүрсэн боловч уг үзүүлэлт нь 2000 оноос 2014 оны хоорондох жилийн дундаж өсөлт 8 хувиас доогуур түвшинд байгаа юм<sup>3</sup>. Хөгжиж буй орнуудын нийт хураамжийн орлогын өсөлтөд тус орнуудын ердийн даатгалын зах зээлийн 60 орчим хувийг<sup>4</sup> эзлэх тээврийн

1 World Bank — World economic prospects/Weak Investment in Uncertain Times/ January 2017

2 Swiss Re (2016a): Global insurance review 2016 and outlook 2017/18, November.

3 IAIS: Global Insurance Market Report 2016

4 Swiss Re (2016b): The future of motor insurance: How car connectivity and ADAS are impacting the market, March

хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний өсөлт томоохон хувь нэмэр оруулжээ. 2016 онд дэлхийн урт хугацааны даатгалын хураамжийн орлого 2015 оны 5 хувийн өсөлтөөс дээшилж, 5.4 хувьд хүрэв. Хөгжингүй орнуудын урт хугацаат даатгалын хураамжийн орлогын өсөлт 2015 онд 3.4 хувь байсан бол 2016 онд 2 хувь болж буурлаа. Дэлхийн амьдралын даатгал, урт хугацааны даалтгалын зах зээл салбарын өсөлтөд хөгжиж буй орнууд, тэр дундаа Азийн хөгжиж буй орнуудын зах зээлийн өсөлт гол нөлөө үзүүлсэн. Хөгжиж буй орнуудын урт хугацаат даатгалын хураамжийн орлогын өсөлт өмнөх оноос 6.9 нэгжээр өсөж 20.1 хувьд хүрэв.

Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/-аас 2014 оны есдүгээр сард хийсэн зах зээлд түшиглэсэн урт хугацааны санхүүжилтийн шийдлээр “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч, дэд бүтцийн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх нь” сэдэвт судалгааны тайланд зах зээлд түшиглэсэн урт хугацааны санхүүжилтийг жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, дэд бүтцийн санхүүжилтийн гэсэн хоёр үндсэн хэлбэрт хуваан авч үзэж, санхүүгийн хэрэгслүүдийг төрөлжүүлсэн байна. Базелийн хорооноос банкуудад тавигддаг өөрийн хөрөнгийн

болон хөрвөх чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн тогтоосноор банкны салбараас олгож байсан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн урт хугацааны санхүүжилтийн хэмжээ буурсан. Үүнээс үүдэн хөгжиж буй болон хөгжингүй орнуудад ЖДҮ эрхлэгч, дэд бүтцийн төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх, банкнаас бусад санхүүжилтийн үйлчилгээг энэ чиглэлд шилжүүлэх шаардлага үүссэн байна.

Бодлого боловсруулагчдын дэлхийн сүлжээ байгууллага болох Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-г өнөөгийн байдлаар дэлхийн хөгжиж буй 95 орнуудын 119 байгууллага /санхүүгийн зохицуулах байгууллага, төв банк/ гишүүнчлэгдэж, дэлхийн бичил санхүүгийн 85 хувийг хамарсан, хөгжиж буй болон хөгжингүй орнуудын санхүүгийн бодлого боловсруулагчдыг хамруулсан, ядуу буурай хүн амд санхүүгийн үйлчилгээг хэрхэн ойртуулах тал дээр анхаарал хандуулан ажиллаж байна. Хороо нь Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн гишүүн бөгөөд 2016 оны есдүгээр сараас эхлэн бүх ажлын хэсэгт орж ажиллан улс, орнуудтай туршлага солилцон идэвхтэй ажиллаж байна.

## 1.2. БАНКНААС БУСАД САНХҮҮГИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Банкнаас бусад санхүүгийн зах зээл 2016 онд 2.6 их наяд төгрөгт хүрч, дунджаар 20 хувиар өссөн ба уг өсөлтөд төрийн дэмжлэг, бодлого зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт голчлон нөлөөлсөн. ДНБ-д эзлэх банкнаас бусад санхүүгийн зах зээлийн хэмжээ 10.9 хувь ба 2015 оны түвшнээс 1.7 хувиар нэмэгджээ.

2015 онд олон нийтэд анх удаа үнэт цаасаа санал болгон гаргасан нэр бүхий хоёр ХК-ийн үнэлгээг 2016 оны зах зээлийн үнэлгээнд оруулж тооцсон нь зах зээлийн үнэлгээ болон хувьцааны арилжааны хэмжээ өсөхөд голчлон нөлөөлсөн. Хорооноос үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, өөрийгөө зохицуулах байгууллагын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор үнэт цаасны бүртгэлийн журамд зохицуулалтын өөрчлөлт хийснээр Хороо болон биржийн чиг үүргийн давхардлыг бууруулж, компаниуд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн бүртгэлд бүртгүүлж, урт хугацааны санхүүжилт татах орчныг улам хялбаршуулсан алхам болоод байна.

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн зах зээл дээр спот арилжааны программыг худалдан авах ажиллагаа явагдаж байгаа ба уг программыг

нэвтрүүлснээр фьючерсийн арилжаа 2017 онд эхлэн, биржээр арилжаалах бараа, түүхий эдийн хөрвөх чадвар сайжирч, арилжааны хэмжээ нэмэгдэнэ.

Даатгалын салбарын хураамжийн орлого 0.6 хувь, нийт хөрөнгө 20.3 хувиар өссөн ба ЗГ-аас тариалан эрхлэгчдийн цаг агаарын таагүй эрсдэлээс хамгаалах чиглэлээр газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, арилжааны даатгалын компаниудаар уг үйлчилгээг дамжуулан 302.4 сая төгрөгийн үнэлгээтэй бүтээгдэхүүнийг даатгажээ. Ипотекийн зээлийн даатгалыг оновчтой хэлбэрээр хэрэгжүүлэх зохицуулалтыг бий болгохоор ажиллаж байна.

ББСБ-уудын тоо 2013 оноос эхлэн огцом нэмэгдэж байгаатай холбоотой Хорооноос тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэр гаргаснаар нийт хөрөнгө 26 хувиар, ББСБ-ын тоо 15 хувиар өссөн. Гэсэн хэдий ч энэ онд ББСБ-аар үйлчлүүлэгчдийн тоо буурч, чанаргүй зээлийн хэмжээ 12.4 хувьд хүрч өмнөх оны мөн үеэс 2.6 нэгжээр нэмэгдэв.

ХЗХ-ны салбарын нийт хөрөнгө 15.8 хувиар, үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын тоо 10.7 хувиар өслөө.

Цаашид ХЗХ-дын хөгжлийг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулах үүднээс Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг шинэчлэх шаардлага үүсээд байна.


### 1.2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас үнэт цаасны зах зээлийн хөгжлийг үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, үнэт цаасны арилжааны ДНБ-д эзлэх хувь, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хувьцааны индекс гэсэн үндсэн үзүүлэлтүүдээр илэрхийлж авч

үздэг бөгөөд тухайн улсын хувьд дээрх үзүүлэлтүүд ямар түвшинд хүрснээс хамаарч гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдэх, хөрөнгө оруулалтын урсгал бий болох, улмаар бүс нутгийн хэмжээнд өрсөлдөхүйц түвшинд байгаа эсэхийг тодорхойлдог.

Зах зээлийн үнэлгээ: Үнэт цаасны зах зээлийн багтаамж, түүний эдийн засгийн өсөлтийг дунд болон урт хугацаанд дэмжигч гол үзүүлэлт нь үнэт цаасны зах зээлийн үнэлгээ бөгөөд энэхүү үзүүлэлтийн өсөлт, бууралт нь үнэт цаасны зах зээлийн хөгжлийн түвшинг, улмаар эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөө үзүүлж байгааг илэрхийлэгч үндсэн индикатор болдог.

Зураг 1. Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлийн үнэлгээ 1474.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 211.7 тэрбум төгрөг буюу 16.8 хувиар өссөн. 2015 онд “МИК холдинг” ХК-ийн 1.6 сая ширхэг хувьцааг 19.5 тэрбум төгрөгөөр, 2016 онд нэр бүхий ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр тус тус олон нийтэд анх удаа санал болгон арилжиж, улмаар 2016 оны нийт зах зээлийн үнэлгээнд дээрх хоёр компанийг оруулж тооцсон нь зах зээлийн үнэлгээ өсөхөд голлох нөлөөг үзүүлсэн.

Мөн 2016 оны 2 дугаар хагасаас олон улсын зах зээл дээр түүхий эдийн үнэ ханш сэргэх төлөв бий болсон нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг нэр бүхий ХК-ийн хувьцааны ханш 19.1 хувиар, манай улсын үнэт цаасны зах зээлийн үнэлгээний дийлэнх хувийг илэрхийлдэг ТОП-20 индексэд багтдаг нэр бүхий 5 компанийн хувьцааны ханш дунджаар 21.94 хувиар тус тус өссөн нь зах зээлийн үнэлгээ өсөхөд нөлөөлжээ.

Зах зээлийн үнэлгээ (ЗЗҮ)-ний дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-д эзлэх хувь, хөрвөх чадварын түвшин: 2016 оны жилийн эцсийн байдлаарх ЗЗҮ-г үйлдвэрлэлийн аргаар тооцсон нэрлэсэн ДНБ-ний хэмжээтэй харьцуулахад 6.2 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өсөжээ. Харин тайлант хугацааны зах зээлийн үнэлгээнд хувьцааны арилжааны үнийн дүнг харьцуулан хөрвөх чадварыг тооцсон дүн 3.3 нэгж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.92 хувиар өссөн байна.


ШИГТГЭЭ. Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2011 онд уул уурхайн салбарын өсөлттэй холбоотойгоор 17.5 хувьд хүрч, бүс нутаг болоод олон улсын хэмжээнд эдийн засгийн өсөлтийн хурдаар тэргүүлэх болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, ТОП–20 индексийг бүрдүүлэгч уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш огцом нэмэгдэх болсон. Үүнийг дагаад Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон мэргэжлийн зуучлагч брокеруудын тоо ихээр нэмэгдсэн байна. Гэвч 2012 оноос хойших хугацаанд олон улсын санхүүгийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ ханш унасан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан, эдийн засгийн өсөлт удааширсан зэрэг шалтгаануудын улмаас Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд буурсаар байна.

Хэдийгээр хөрөнгийн зах зээлийн хөгжлийн суурь нөхцөл болох үнэт цаасны зах зээлийн хууль, эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, хяналт, зохицуулалтын оновчтой тогтолцоо бүрдэх боломж бий болж байгаа хэдий ч, хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийн хөгжил сул, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадвар доогуур, үр ашигтай хяналт, зохицуулалтын механизм бүрдээгүй зэрэг нь хөрөнгийн зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Хөрвөх чадварын түвшин өсөхөд нэр бүхий ХК–ийн 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр хувьцааны анхдагч зах зээлд арилжсан болон багцын арилжаагаар нэр бүхий 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь голлох нөлөөг тус тус үзүүлсэн бөгөөд багцын арилжаа нийт хувьцааны арилжааны 69.6 хувийг бүрдүүлсэн.

Манай улсын хувьд хувьцааны хөрвөх чадварын түвшин бусад хөгжиж буй орнуудтай харьцуулахад доогуур түвшинд байгаа ба үүнд “Монголын хөрөнгийн бирж” ХК–д бүртгэлтэй компаниудын хувьцаа хэт төвлөрсөн, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдал муу, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ байхгүй, олон нийтийн хөрөнгө оруулалт, хувьцааны талаарх мэдлэг, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйлс гол нөлөөг үзүүлж байна.


Зураг 2. Зах зээлийн үнэлгээ ба Дотоодын нийт бүтээгдэхүүн



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн оролцогчид: Тайлант хугацаанд Хорооны үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд нийт 302 хувьцаат компани бүртгэлтэй байна.

Зураг 3. Хувьцаат компанийн тоо



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хорооны зүгээс “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нэр хүндийг өсгөх, үнэт цаасны бүртгэлийн ангиллыг шинэчлэх, бүртгэлийн хэлбэрээс зөвшөөрлийн хэлбэрт шилжүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах хүрээнд өмч хөрөнгө нь үрэгдсэн, хувьцаа эзэмшигчдийн

өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй компаниудын үнэт цаасыг бүртгэлээс хасах, компанийн засаглал, санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 1. Хувьцаат компанийн өмчийн хэлбэр, тоо

Үнэт цаас гаргагчийн өмчийн бүтэц	Хороо	“Монголын хөрөнгийн бирж” ХК	“ҮЦТТТХТ” ХХК
Төрийн өмчит	31	19	21
Төрийн өмчийн оролцоотой	19	15	22
Хувийн өмчит	252	185	269
Нийт	302	219	312

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчид: Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 62 үнэт цаасны компани үнэт цаасны арилжаа эрхлэх 2, үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх 1, төвлөрсөн хадгаламжийн 1, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэх 3, хөрөнгө оруулалтын менежментийн 12, хөдөө аж ахуйн биржийн арилжаа, зуучлалын чиглэлээр арилжаа эрхлэх 1, бараа, түүхий эдийн арилжааны зуучлалын үйл ажиллагаа эрхлэх 37 хуулийн этгээд Хорооноос тусгай зөвшөөрөлтэй байна.

2016 онд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан нийт 348.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 36.1 хувиар буурчээ. Нийт арилжааны 14.1 хувийг хувьцаа, 85.9 хувийг ЗГҮЦ-ны арилжаа тус тус эзэлсэн байна.

ШИГТГЭЭ. Манай улс үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн хөгжлөөр ижил түвшний бусад орнуудтай харьцуулахад хангалтгүй, тэр дундаа төлбөр, тооцоо, арилжааны систем болон мэргэжлийн зуучлагч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо хангалтгүй, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлт хомс, үнэт цаасны арилжаа, хөрвөх чадварын түвшин доогуур байгаа нь зах зээлийн хөгжилд сөрөг нөлөөг үзүүлж байна.

Хорооны зүгээс Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны хоёр дахь шатны төслийн хүрээнд санхүү, хүний нөөц, техник программ хангамжийн хувьд чадавхтай мэргэжлийн зуучлагч компаниудыг бий болгох замаар төлбөрийн баталгааны санг байгуулах, өөрийн орны онцлогтой нийцүүлэн төлбөр, тооцоонд DVP /төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ загварыг бүрэн нэвтрүүлэх, арилжааны дараах төлбөр тооцооны горимыг Т+2 эсхүл Т+3–д зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан шилжүүлэх, урт хугацаанд тооцооны байгууллага байгуулагдах урьдчилсан нөхцөлийг бүрдүүлж, улмаар гадаадын хөрөнгө оруулагчдын арилжаанд оролцох оролцоог нэмэгдүүлэх болон үнэт цаасны зах зээлд итгэх итгэлийг сэргээх бодлогын чиглэлийг баримтлан ажиллаж байна.

Цаашид үнэт цаасны зах зээл дээр мэргэшсэн боловсон хүчинтэй, санхүүгийн чадавхтай, холбогдох хууль тогтоомж болон Хорооноос тогтоосон шалгуур үзүүлэлтийг хангаж ажилладаг ҮЦК–иуд бий болсноор төлбөрийн баталгааны сан байгуулагдах нөхцөлийг бүрдүүлж, дэд бүтцийн хөгжил болоод үнэт цаасны зах зээлийн арилжаа, хөрвөх чадварын түвшин нэмэгдэх, төлбөр, тооцооны горим олон улсын стандартад нийцсэн Т+2, эсхүл Т+3–д шилжих боломж бүрдэнэ.

#### Хүснэгт 2. Арилжааны үзүүлэлт

Үнэт цаасны төрөл		Хийгдсэн арилжааны тоо	Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	1	33.9	6.3
	Хоёрдогч зах зээл	244	59.8	42.7
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	31	3.1	280.5
	Хоёрдогч зах зээл	77	0.196	19.2


Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

Хувьцааны арилжаа: “Монголын хөрөнгийн бирж” ХК–ийн 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 69.6 хувь буюу 34.1 тэрбум

төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.4 хувь буюу 14.9 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлсэн.



Зураг 4. Хувьцааны арилжаа /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд багцын арилжаагаар нийт 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 69.6 хувийг эзэлсэн байна.

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа: Тайлант хугацаанд “МИК ОССК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “МИК

актив найм ТЗК” ХХК, “МИК актив ес ТЗК” ХХК, “МИК актив арав ТЗК” ХХК, “МИК актив арван нэг ТЗК” ХХК гэсэн дөрвөн тусгай зориулалтын компанийн нийт 7730 зээлдэгчдийн зээлийн багц бүхий 501.2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

Хүснэгт 3. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас /тэрбум төгрөг/

ХБҮЦ гаргагч	Нийт гаргасан үнэт цаас	“ҮЦТХТ” ХХК-д бүртгэгдсэн	Зээлдэгчийн тоо
“МИК актив нэг ТЗК” ХХК	328.1	322.9	6,658
“МИК актив хоёр ТЗК” ХХК	224.8	222.1	5,290
“МИК актив гурав ТЗК” ХХК	328.5	324.6	6,593
“МИК актив дөрөв ТЗК” ХХК	459.4	452.3	9,510
“МИК актив тав ТЗК” ХХК	301.2	294.3	5,805
“МИК актив зургаа ТЗК” ХХК	267.8	261.7	5,188
“МИК актив долоо ТЗК” ХХК	299.6	293.8	5,414
“МИК актив найм ТЗК” ХХК	189.8	186.3	3,291
“МИК актив ес ТЗК” ХХК	137.5	137.2	1,719
“МИК актив арав ТЗК” ХХК	103.0	–	1,585
“МИК актив арван нэг ТЗК” ХХК	70.9	–	1,135
Нийт	2,710.6	2,495	52,188

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Хөдөө аж ахуйн биржийн арилжаа: “ХААБ” ХХК-иар дамжин 181 удаагийн арилжаа явагдаж, нийт 463 тэрбум төгрөгийн бараа, түүхий эд арилжаалагдсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 29.1 тэрбум төгрөг буюу 6.7 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ. Нийт арилжааг бүтцээр нь ангилан үзвэл, ноолуур 409.7 тэрбум төгрөг, хонины ноос 26.2 тэрбум төгрөг, тэмээний ноос 3.9 тэрбум төгрөг, ямааны завод ноос 3 сая төгрөг, бодын хөөврийг 70 сая төгрөгөөр тус тус арилжаалсан байна.

## 2016 Үйл ажиллагааны тайлан


Үнэт цаасны зах зээл дэх хөрөнгө оруулагчид, дансны бүтэц: “Монголын хөрөнгийн бирж” ХК–д хоёрдогч зах зээлийн төвлөрсөн хадгаламжид өссөн дүнгээр нийт 886,590 данс, 139,228 холболтын данс нээгдсэн.

Нийт дансыг бүтцээр нь үзвэл, 881,962 дотоодын иргэн, 1,920 гадаадын иргэн, 2,530 дотоодын аж ахуйн нэгж, 178 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус байна. Тайлант хугацаанд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид нийт 81,017 данс шинээр нээгдсэнээс 80,899 нь дотоодын

иргэн, 66 нь гадаадын иргэн, 50 нь дотоодын аж ахуйн нэгж, 2 гадаадын аж ахуйн нэгжийн данс тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК–ийн арилжааны үнийн дүнд гадаадын аж ахуйн нэгж болон иргэдийн эзлэх хэмжээ 2.0 хувь бол дотоодын аж ахуйн нэгж болон дотоодын иргэдийн эзлэх хэмжээ 98.0 хувьтай байна.

Зураг 5. Хөрөнгө оруулагчдын арилжаанд эзлэх хэмжээ /хувь/



Эх сурвалж: “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК

2016 онд, манай улсын макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд буурсан, эдийн засгийн өсөлт удааширсан таагүй нөхцөл байдалд үнэт цаасны зах зээлийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болох зах зээлийн үнэлгээ, хөрвөх чадвар, хувьцааны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн байгаа нь манай улсын хөрөнгийн зах зээл дээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын идэвх сэргэхэд нөлөөлөх эерэг хүчин зүйл юм.

Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд гадаад, дотоодын нийт 81,017 данс шинээр нээгдсэн байна. Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлд нийт 501.2 тэрбум төгрөгийн үнэт

цаас арилжаалагдсан ба энэ нь цаашид уг зах зээлийн хоёрдогч зах зээл хөгжих, олон нийтэд үнэт цаас нь нээлттэй арилжаалагдах боломжийг нэмэгдүүлнэ.

Мөн үнэт цаасны зах зээлийн хууль эрх зүйн, зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2016 онд Улсын Их хурал (УИХ)–аас баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”–д салбарын холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэ харилцааг зохицуулсан хуулийн төсөл боловсруулах саналуудыг тусгасан байна.


## 1.2.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгал нь даатгуулагчийн эрсдэлийг дахин хуваарилах, шилжүүлэх, санхүүгийн нөөцийн хуваарилалтыг оновчтой болгож, хөрөнгө оруулалтыг дэмжин эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх ба санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал ач холбогдолтой салбар юм.

Салбарын бодит эдийн засагт үзүүлэх нөлөөллийг авч үзвэл, 2016 оны байдлаар даатгалын салбарын нийт актив ДНБ-ний 0.87 хувийг эзэлж байгаа нь өмнөх онтой харьцуулахад 27.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ШИГТГЭЭ. Тайлант хугацаанд салбарын нэвтрэлт буюу ДНБ-д эзлэх цэвэр хураамжийн орлого 0.48 хувь байгаа нь хөгжиж буй зах зээлтэй орнуудын дунджаас 5.8 дахин, дэлхийн дунджаас 13.5 дахин бага байна. (Эх сурвалж: OECD, Global insurance trends 2015)

Зураг 6. Даатгалын нэвтрэлт, нягтрал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцсийн байдлаар нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ 36,700.0 төгрөг байгаа нь өмнөх оноос 1.4 хувиар буурсан байна.

## ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

2016 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарт Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй 17 даатгалын компани, 40 даатгалын зуучлагч компани, 31 даатгалын хохирол үнэлэгч компани болон даатгалын компанийн 242 салбар, 10 төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 208 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 50 салбар, 2 төлөөлөгчийн газар тус тус үйл ажиллагаа явуулж байна.


Хүснэгт 4. Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчдийн тоо

№		2010	2011	2012	2013	2014	2015	2016
1	Ердийн даатгалын компани	16	16	17	16	16	15	15
2	Урт хугацааны даатгалын компани	1	1	1	1	1	1	1
3	Давхар даатгалын компани	–	–	–	–	–	1	1
4	Даатгалын төлөөлөгч	2061	2057	2357	3187	3260	3340	3091
5	Даатгалын зуучлагч	9	8	17	20	30	37	40
6	Даатгалын хохирол үнэлэгч	6	9	9	14	20	27	31
7	Актуарч	12	13	18	15	15	15	15
	БҮГД	2104	2103	2419	3253	3342	3436	3194

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгагчийн хөрөнгө: Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ 2016 оны жилийн эцсийн байдлаар 208.4 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 35.2 тэрбум төгрөгөөр буюу 20.3 хувиар өсөжээ.

Зураг 7. Компаниудын нийт хөрөнгө, хөрөнгийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Салбарын хэмжээнд нийт хөрөнгөд эзлэх хувиар авч үзвэл, ердийн даатгалын компаниудын хөрөнгө 79.6 хувь, давхар даатгалын компани 16.8 хувь, урт хугацааны даатгалын компани 3.6 хувийг тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниуд 1,069,856 иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 114.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсэн байна. Даатгалын нийт хураамжийн

орлогын 97.5 хувь буюу 111.7 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 1.1 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 1.6 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани төвлөрүүлсэн байна. Даатгалын нийт хураамжийн орлого өмнөх оноос 0.6 тэрбум төгрөгөөр буюу 0.6 хувиар өссөн байна.

Зураг 8. Даатгалын компаниудын хураамжийн орлого, давхар даатгалын хураамж



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жич: 2015 оноос эхлэн давхар даатгалын компаний хураамжийн орлого нэмэгдсэн.


Даатгалын нийт хураамжийн орлогын 75.5 хувь нь гэнэтийн осол эмчилгээний, хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, жолоочийн хариуцлагын даатгалын гэсэн 4 хэлбэрийн хураамжийн орлогоос бүрджээ.

Хүснэгт 5. Даатгалын хураамжийн нийт орлого /хэлбэрээр/

Д/д	Даатгалын хэлбэр	Даатгалын хураамжийн нийт орлого		Өөрчлөлт/ Бууралт
		2015	2016	
1	Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	10,612,015,862.3	12,331,737,772.7	16.2%
2	Хөрөнгийн даатгал	40,884,297,808.4	31,793,234,171.0	-22.2%
3	Авто тээврийн хэрэгслийн даатгал	15,676,414,189.5	14,481,925,482.9	-7.6%
4	Ачааны даатгал	2,375,826,966.0	1,943,624,943.2	-18.2%
5	Барилга угсралтын даатгал	2,002,547,550.0	3,266,532,235.1	63.1%
6	Газар тариалангийн даатгал		13,699,146.0	
7	Мал амьтдын даатгал	709,666,385.7	1,158,512,708.2	63.2%
8	Агаарын хөлгийн даатгал	3,489,678,425.5	3,211,073,279.2	-8.0%
9	Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	389,586,492.0	458,880,469.9	17.8%
10	Хариуцлагын даатгал	7,335,783,807.5	7,857,252,716.7	7.1%
11	Санхүүгийн даатгал	3,197,292,592.5	3,232,588,355.9	1.1%
12	Зээлийн даатгал	769,849,914.4	1,032,576,630.7	34.1%
13	Итгэлцлийн даатгал	25,292,935.7	280,580,893.7	1009.3%
14	Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал	1,817,649,110.7	2,818,819,047.1	55.1%
15	Жолоочийн хариуцлагын даатгал	22,927,430,530.5	27,795,509,631.4	21.2%
16	Хугацаат амьдралын даатгал	345,164,043.8	176,891,345.0	-48.8%
17	Насан туршийн даатгал	-	-	-
18	Хуримтлалын даатгал	75,148,081.5	69,836,168.0	-7.1%
19	Тэтгэврийн даатгал	47,873,111.4	55,043,569.8	15.0%
20	Эрүүл мэндийн даатгал	1,184,640,990.9	966,913,930.5	-18.4%
21	Аннуити даатгал	-	-	-
22	Газар тариалангийн давхар даатгал	-	13,014,188.7	
23	Мал амьтдын давхар даатгал	-	1,543,701,794.6	
	Нийт дүн	113,866,158,798.2	114,501,948,480.0	

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Зураг 9. Даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын нөхөн төлбөр: Тайлант хугацаанд даатгалын тохиолдлын улмаас нийт 64,276 даатгуулагчдад 34.3 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оноос 6.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг 10. Даатгалын нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Даатгалын нөхөн төлбөрийг хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 33,188 даатгуулагчдад нийт 14.8 тэрбум төгрөг, авто тээврийн хэрэгслийн даатгалын 14,267 даатгуулагчдад 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр үзүүлэлтүүд байв.

Даатгалын хохирлын харьцаа: Тайлант хугацаанд салбарын хэмжээнд хохирлын харьцаа нь 31.4 хувьтай

байна. Мөн даатгалын компаниудын хувьд даатгалын цэвэр хураамжийн орлогоос тооцсон орлогод тооцсон хураамж, даатгагчаас олгосон нөхөн төлбөрийн харьцаагаар тооцоход салбарын хэмжээнд хохирлын харьцаа 42.2 хувьтай байна.

Тайлант хугацаанд даатгалын компаниудын цэвэр ашиг 11.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 4.3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 11. Тайлант хугацааны цэвэр ашиг /тэрбум төгрөг/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Албан журмын даатгал: 2016 онд ердийн даатгалын 15 компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхэлсэн байна. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар нийт 463,802

иргэнтэй даатгалын гэрээ байгуулж, даатгалын компаниуд тайлант жилд 27.8 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зураг 12. Даатгалын нийт хураамжийн орлого, нөхөн төлбөр



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Жолоочийн даатгалын тухай хуульд зааснаар Жолоочийн даатгалын санд нийт 3,787.1 сая төгрөг төвлөрч, нийт 150.0 сая төгрөгийг дээрх хуульд заасан үндэслэлээр нөхөн төлбөрт олгожээ.

даатгалын хураамж өмнөх оны мөн үеэс 9.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Даатгалын компаниуд гадаадын давхар даатгагчид нийт 37.2 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн нь нийт хураамжийн 32.5 хувьтай тэнцэж, давхар

Даатгалын компаниудын тайлант үеийн цэвэр ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 60.5 хувиар өссөн байна.

Даатгагч нарын ашигт ажиллагаанд гол нөлөөлөх харьцаануудыг тооцвол, салбарын хэмжээнд нийт хөрөнгийн өгөөж 35.4 хувь, үндсэн үйл ажиллагааны зардлын харьцаа 49.5 хувь, хохирлын харьцаа 42.2 хувь, зардал ба хохирлын хосолсон харьцаа 91.7 хувьтай байв.

Даатгалын салбарын үндсэн үзүүлэлтүүд сүүлийн жилүүдэд тогтмол өсөлттэй байгаа хэдий ч салбарын хөгжлийн гол хэмжүүрүүд болох даатгалын нэвтрэлт, нягтрал нь олон улсын дундаж түвшинтэй харьцуулбал доогуур, сүүлийн жилүүдэд өсөлт ажиглагдахгүй байна.

Орон сууцны ипотекийн зээлдэгчийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах саналыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн ээлжит хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав. Санхүүгийн “Фин-А” системийн мэдээллийн чанарыг сайжруулах, хугацааны цуваа бүхий иж бүрэн мэдээллийн санг бий болгох зорилгоор даатгалын байгууллагуудын 2006 оноос хойших санхүүгийн тайлан, мэдээллийг “Фин-А” системд нөхөж оруулан даатгалын салбарын тоон мэдээлэлд үндэслэн судалгаа, шинжилгээ хийх боломжийг бүрдүүлэв.

### 1.2.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах, салбарын үйл ажиллагааг дэмжих, нэгдсэн цогц бодлогын хүрээнд Банк бус санхүүгийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр Хорооны 2016 оны 71 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны


зохицуулалтын журам, заавар”, 147 дугаар тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталж, 271 дүгээр тогтоолоор “Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон бөгөөд тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

Хорооны тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх ББСБ-уудын тоо 2016 оны жилийн эцэст 518 болж өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар өссөн байна.

ББСБ-ууд нь бичил, жижиг, дунд, өрхийн бизнес эрхлэгчдэд зээл, валют арилжаа, итгэлцэл, факторинг, цахим төлбөр тооцоо мөнгөн гуйвуулга, төлбөрийн баталгаа, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах зэрэг санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрөл, зохицуулалтын хүрээнд хүргэж үйлчилдэг.

Тайлант оны эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт ББСБ-ын зээлийн үйл ажиллагааг 463, гадаад валютын арилжааг 144, хөрөнгө оруулалт санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх үйл ажиллагааг 33, итгэлцлийн үйлчилгээг 28, факторингийн үйлчилгээг 22, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээг 16, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээг 12, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээг тус тус 2 ББСБ эрхэлж байна.

Зураг 13. ББСБ-уудын тооны өөрчлөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Тайлант хугацааны голлох статистик үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харуулбал:

*Хүснэгт 6. Үндсэн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/*

Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015	2016	Өөрчлөлт
		дүн	дүн	хувиар
1	Нийт ББСБ–ын тоо	450	518	15.1
	Үүнээс: хөдөө орон нутагт	50	60	20.0
2	Харилцагчдын тоо	636,341	592,461	(6.9)
3	Хувьцаа эзэмшигчдийн тоо	922	1,042	13.0
4	Ажиллагсдын тоо	1,995	2,115	6.0
5	Салбар нэгжийн тоо	116	124	6.9
	Үүнээс: Улаанбаатар хотод	86	92	7.0
	Үүнээс: Хөдөө орон нутагт	30	32	6.7
6	Төлөөлөгчийн газар	4	4	–
7	Нийт хөрөнгө	623,172,524.1	787,172,010.1	26.3
	Банкны салбартай харьцуулахад /хувиар/	3.0%	3.1%	0.1%
8	Нийт эзэлийн өрийн үлдэгдэл	391,235,479.1	478,175,223.3	22.2
	Банкны салбартай харьцуулахад /хувиар/	3.4%	3.9%	0.5%
9	Нийт өөрийн хөрөнгө	424,210,836.2	578,491,202.8	36.4
	Банкны салбартай харьцуулахад /хувиар/	16.8%	18.6%	1.8%
10	Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө	308,451,260.0	440,547,491.2	42.8
	Банкны салбартай харьцуулахад /хувиар/	65.6%	68.8%	3.2%

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Оны эцэст Хорооноос 144 ББСБ нь гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгаагаас 35.4 хувь буюу 51 компани нь дагнан эрхэлж байна. Тайлант онд гадаад валют арилжааны ББСБ–ууд нийт 990.3 тэрбум төгрөгийн валют худалдан авч 1,017.3 тэрбум төгрөгийн валют худалдсан байна.

Нийт актив: Банк бус санхүүгийн салбарын нийт хөрөнгө 787.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 26.3 хувиар буюу

163.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлтөд ББСБ–уудын өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар, үүний дотор хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар өссөн нь голчлон нөлөөлж байна.

Нийт активын 95.8 хувийг эргэлтийн хөрөнгө эзэлж байгаагийн 55.4 хувийг зээл, 30.9 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Үүнд:

Хүснэгт 7. Активын бүтэц

№	ХӨРӨНГӨ	2015		2016		Өөрчлөлт
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Хувиар
A	Эргэлтийн хөрөнгө	600,422,405.40	96.3	754,283,187.50	95.8	25.6
1	Мөнгөн хөрөнгө	174,217,117.50	28	243,107,520.30	30.9	39.5
2	Нийт зээл	391,235,479.10	62.8	478,175,223.30	60.7	22.2
	(Зээлийн эрсдэлийн сан)	26,556,625.70	4.3	42,065,155.70	5.3	58.4
3	Бусад хөрөнгө	46,944,361.50	7.5	69,275,036.90	8.8	47.6
Б	Эргэлтийн бус хөрөнгө	22,750,118.70	3.7	32,888,822.60	4.2	44.6
1	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	28,541,236.30	4.6	40,100,706.80	5.1	40.5
НИЙТ ХӨРӨНГӨ		623,172,524.10	100	787,172,010.10	100	26.3

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ББСБ-ын салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх улирлаас 6.8 хувиар буюу 30.8 тэрбум төгрөгөөр өсөж 478.2 тэрбум төгрөгт хүрч, 66449 зээлдэгчид үйлчилсэн байна. Нийт зээлд злэх гадаад валютаар олгосон зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 4.2 тэрбум төгрөгөөр буюу 10.8 хувийн, төгрөгөөр олгосон зээлийн хэмжээ 82.7 тэрбум төгрөгөөр буюу 23.5 хувийн өсөлттэй байна.

Нийт зээлийн өрийн үлдэгдлийн 82.0 хувь нь хэвийн зээл, 5.6 хувь нь хугацаа хэтэрсэн зээл, чанаргүй зээл 12.4

хувь буюу 59.5 тэрбум төгрөгт хүрлээ. Чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 55.1 хувиар өссөн хэдий ч өмнөх улирлаас 5.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зээлд злэх чанаргүй зээлийн ангиллын төрөл тус бүрийн хэмжээ нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 21.1 тэрбум төгрөгөөр буюу 55.1 хувиар өссөн явдал нь муу зээлийн хэмжээ 69.9 хувиар өссөнтэй шууд хамааралтай.

Зураг 14. Зээлийн багцын чанар /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Олгосон зээлийн өрийн үлдэгдлийг эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудаар авч үзвэл 2016 онд хэрэглээний зээлд 35.8 хувь буюу 197.5 тэрбум төгрөг, худалдааны салбарт 21.8 хувь буюу 120.3 тэрбум төгрөг,

уул уурхайн салбарт 17.6 хувь буюу 96.8 тэрбум төгрөг, барилгын салбарт 10.9 хувь буюу 60.1 тэрбум төгрөг бусад салбаруудад 13.9 хувь буюу нийт 76.3 тэрбум төгрөгийн зээлийг тус тус олгосон байна.

Зураг 15. Салбарын ангиллаар олгосон зээл /оны эхнээс өссөн дүнгээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй нийт 454 ББСБ-ын зээлийн сарын жигнэсэн дундаж хүү 4.0 хувьд хүрч өмнөх улирлаас

0.2 хувиар буурсан бөгөөд банкны салбарын хүүтэй харьцуулахад хүүгийн зөрүү 2 хувь байна.

Зураг 16. Зээлийн жигнэсэн дундаж хүү



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Активын бусад үзүүлэлт: Тайлант жилд 16 ББСБ богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгсэлд 1.3 тэрбум төгрөгийг байршуулсны 89.6 хувь буюу 1.2 тэрбум төгрөгийг нэг компанийн хувьцаагаар хийсэн хөрөнгө оруулалт дангаараа бүрдүүлж байгаа бол 15 ББСБ 1 сая төгрөгөөс 33.9 сая хүртэлх хэмжээний мөнгөн хөрөнгийг арилжааны болон хөрөнгө оруулалтын үнэт цаасанд байршуулсан байна.

Түүнчлэн ББСБ-ын факторингийн тооцооны авлага данс 37.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 30 сая төгрөгийн авлага муу ангилалд ангилагдан эрсдэлийн сан байгуулсан байна.

Тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулж буй 518 ББСБ нь 40.1 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгөд 7.2 тэрбум төгрөгийн элэгдэл тооцсон байна.

## 2016 Үйл ажиллагааны тайлан

ББСБ–ын салбарын нийт эх үүсвэрийн хэмжээ 2016 оны эцэст өмнөх оны мөн үеэс 26.3 хувиар өссөн бөгөөд 208.7 тэрбум төгрөг буюу 26.5 хувийг бусдаас татсан эх үүсвэр, 578.5 тэрбум төгрөг буюу 73.5 хувийг өөрийн хөрөнгө бүрдүүлж байгаагийн 56 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 16.6 хувийг хуримтлагдсан ашиг, 15.4 хувийг банк санхүүгийн байгууллагаас авсан зээл, 3.9 хувийг

итгэлцлийн үйлчилгээний өр, үлдсэн хувийг бусад эх үүсвэр бүрдүүлж байна. Өөрийн хөрөнгө 154.3 тэрбум төгрөгөөр буюу 36.4 хувиар нэмэгдэж, 578.5 тэрбум төгрөгт хүрэхэд хувь нийлүүлсэн хөрөнгө 132.1 тэрбум төгрөгөөр буюу 42.8 хувиар, хуримтлагдсан ашиг 28.4 тэрбум төгрөгөөр буюу 27.8 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

### Хүснэгт 8. Өр төлбөр ба эздийн өмч

Д/д	ХӨРӨНГӨ	2015		2016		Өөрчлөлт
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Хувиар
A	Эргэлтийн хөрөнгө	600,422,405.40	96.3	754,283,187.50	95.8	25.6
1	Мөнгөн хөрөнгө	174,217,117.50	28	243,107,520.30	30.9	39.5
2	Нийт зээл	364,678,853.40	58.50	436,110,067.60	55.40	20%
3	Бусад хөрөнгө	46,944,361.50	7.5	69,275,036.90	8.8	47.6
Б	Эргэлтийн бус хөрөнгө	22,750,118.70	3.7	32,888,822.60	4.2	44.6
1	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	28,541,236.30	4.6	40,100,706.80	5.1	40.5
	<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>623,172,524.10</b>	<b>100</b>	<b>787,172,010.10</b>	<b>100</b>	<b>26.3</b>

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны тайлант жилд 4 ББСБ–ын мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг 1 тэрбум төгрөг, нэг компанийн төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 2.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол 6 ББСБ нийт 0.99 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг хоёрдогч өглөг, 7 ББСБ нийт 4.1 тэрбум төгрөгийг өрийн бичиг гаргах замаар татан төвлөрүүлсэн байна. Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өр, хоёрдогч өглөгөөр татан төвлөрүүлсэн хөрөнгө нь салбарын нийт өр төлбөрийн 0.5 хувь, төлбөр тооцооны үйлчилгээний өглөг 1.3 хувь, өрийн бичгээр татан төвлөрүүлсэн хөрөнгө мөн үзүүлэлтийн 2 хувьтай тус тус тэнцэж байна.

2016 оны жилийн эцэст ББСБ–уудын нийт орлого өмнөх оны мөн үеэс 23.9 хувиар өсөж 193.4 тэрбум төгрөгт хүрсэн байна. Нийт орлогын 70.1 хувийг хүүгийн орлого, 28.1 хувийг хүүгийн бус орлого, 1.8 хувийг үндсэн бус үйл ажиллагааны орлого бүрдүүлж байна.


Тайлант оны эцэст нийт зардал өмнөх оны мөн үеэс 22.5 хувиар өсөж 134.4 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд хүүгийн зардал 2.9 хувиар, хүүгийн бус зардал 24.8 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 28.9 хувиар, орлогын татварын зардал 14.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй гарлаа.

ШИГТГЭЭ. Салбарын хэмжээнд 416 ББСБ 63.9 тэрбум төгрөгийн ашигтай ажилласнаар улсын төсөвт 7 тэрбум төгрөгийн орлогын албан татвар төвлөрүүлж байна.

Тайлант хугацаанд 59.0 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үеэс 12.7 тэрбум төгрөгөөр буюу 27.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ББСБ–уудын нийт орлого, зардлын үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулбал:

Зураг 17. Ашигт ажиллагааны үзүүлэлт /тэрбум төгрөгөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй 518 ББСБ-ын 427 ББСБ буюу 82.4 хувь нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж ажилласан бол 60 ББСБ буюу 11.6 хувь нь 1 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 19 ББСБ буюу 3.7 хувь нь 2 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 6 ББСБ буюу 1.2 хувь нь 3 харьцаа үзүүлэлтийг хангаагүй, 6 ББСБ буюу 1.2 хувь нь 4-өөс дээш харьцаа үзүүлэлтийг хангаагүй ажилласан байна.

ББСБ-уудын нийт актив 787.2 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.1 хувь, зээлийн өрийн үлдэгдэл 478.2 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 3.9 хувь, өөрийн хөрөнгө 578.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 18.6 хувь, хувь нийлүүлсэн хөрөнгө 440.5 тэрбум төгрөг байгаа нь банкны салбарын мөн үзүүлэлтийн 68.8 хувьтай тус тус тэнцэж байна.

ББСБ-уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тэдгээрийн хувь нийлүүлсэн хөрөнгийг үе шаттай нэмэгдүүлэх шийдвэртэй холбогдуулан ББСБ-уудын нийт актив 2016 оны эцэст 787.2 тэрбум төгрөгт


хүрсэн бөгөөд 2017 оны эцэст 26 хувиар өсөж 992.5 тэрбум төгрөгт хүрэх төсөөлөлтэй байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэж, салбарт эерэг үр дүн үзүүлнэ гэж үзэж байна.

#### 1.2.4. ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

Хадгаламж, зээлийн хоршоо нь зөвхөн гишүүдийнхээ хүрээнд хадгаламж, зээлийн үндсэн үйлчилгээг үзүүлж, тэдний орлогыг бодитой нэмэгдүүлэх, ажил эрхлэлтийг дэмжих, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн үйлчилгээг үзүүлдэг, ашгийн төлөө бус, иргэдэд хамгийн ойр, хамтын санхүүгийн байгууллага юм. Бусад санхүүгийн байгууллагуудаас, хөрөнгийн нэгдэл төдийгүй, иргэдийн нэгдэл байдгаараа ялгардаг.

2016 онд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх 34 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 7 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 280 ХЗХ үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 18. ХЗХ-дын тооны өөрчлөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт хадгаламж, зээлийн хоршоодын 65.7 хувь буюу 184 нь Улаанбаатар хотод, 34.3 хувь буюу 96 нь орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс банк, санхүүгийн үйлчилгээний төвлөрөл, хүн амын нягтаршлаа дагаад Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдэд хамгийн их төвлөрсөн байна.

Хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-дын хувьд энэхүү үзүүлэлт Орхон, Баян-Өлгий, Завхан аймгуудад хамгийн их байгаа бол Ховд, Говь-Алтай, Говьсүмбэр аймгуудад тус бүр 1 ХЗХ /Зураг 19/ үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 19. ХЗХ-дын тоо /байршлаар/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Монголын хоршооллын үндэсний V чуулганаар хоршоодын хөгжилд тулгамдаж буй асуудлуудыг хамтран хэлэлцэж, УИХ, ЗГ-аас батлан хэрэгжүүлж буй “Тогтвортой хөгжил”, “Ногоон хөгжил, ногоон эдийн засаг”-ийн хөгжлийн бодлого, зорилтууд, “Мах, сүүний аян”, “Түүхий эд бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо”-г бий болгох тэдгээрийн хэрэгжилтэнд хоршоодын оролцоог

нэмэгдүүлэх, хоршооны сайн засаглалыг хөгжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааны дундын шинэ загвар бий болгох талаар хэлэлцэж хоршооллын салбарын цаашдын бизнесийн шинэ гарцыг тодорхойлсон бөгөөд санхүүгийн байгууллага талаасаа ХЗХ-ны үүрэг маш чухлыг онцолсон.

Зураг 20. ХЗХ-дын гишүүдийн тооны өөрчлөлт



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 оны жилийн эцсийн байдлаарх салбарын ерөнхий статистик үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 9. Үндсэн үзүүлэлтүүд


Д/д	Үндсэн үзүүлэлтүүд	2015	2016	Өөрчлөлт	
				дүн	хувь
1	ХЗХ–дын тоо	253	280	27	10.7%
2	Гишүүдийн тоо	39,146	46,183	7,037	18.0%
3	Нийт актив	97,698,233.8	113,131,578.4	15,433,344.6	15.8%
	Банкны салбарт эзлэх хувь	0.5%	0.5%	–	–
4	Нийт зээлийн үлдэгдэл	75,339,140.6	84,442,032.9	9,102,892.3	12.1%
	Банкны салбарт эзлэх хувь	0.6%	0.7%	0.1%	16.6%
5	Нийт чанаргүй зээлийн үлдэгдэл	3,466,986.9	4,620,960.2	1,153,973.3	33.3%
	Банкны салбарт эзлэх хувь	0.4%	0.4%	–	–
6	Нийт татан төвлөрүүлсэн хадгаламжийн үлдэгдэл	59,262,286.8	68,149,279.5	8,886,992.7	15.0%
	Банкны салбарт эзлэх хувь	0.8%	0.8%	–	–
7	Нийт хувь хөрөнгийн үлдэгдэл	10,637,537.3	12,167,436.5	1,529,899.2	14.4%
8	Нийт хоршоологчдын өмчийн үлдэгдэл	10,569,495.5	12,119,877.0	1,550,381.5	14.7%
9	Банк, ББСБ, төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн үлдэгдэл	12,555,227.0	15,481,372.7	2,926,145.7	23.3%
10	Нийт орлого	21,752,831.5	24,709,072.4	2,956,240.9	13.6%
11	Нийт зардал	18,507,722.2	20,878,463.8	2,370,741.6	12.8%
12	Тухайн үеийн ашиг, алдагдал	3,245,109.3	3,830,608.6	585,499.3	18.0%

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант жилд ХЗХ–ны тоо өмнөх оноос 10.7 хувиар, гишүүдийн тоо 18.0 хувиар, нийт активын хэмжээ 15.8 хувиар тус тус өссөн бөгөөд активын 74.9 хувийг зээлийн багц эзэлж байна. Нийт актив болон зээлийн банкны салбарт эзлэх хувь өсөж байгаа нь “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”–т 123 ХЗХ хамрагдсантай холбоотой бөгөөд банк, ББСБ,

төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 15.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Цаашид нэн тэргүүнд хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа ХЗХ–доор жижиг, дунд, үйлдвэрлэгчид, сум орон нутгийг дэмжих төсөл, хөтөлбөр, бөөний зээлийг дамжуулан хүргэх боломжийг судлан ажиллаж байна.

Зураг 21. Салбарын хэмжээгээр нийт активын өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



2016 оны эцсийн байдлаар ХЗХ-дын нийт зээлийн багц 84.4 тэрбум төгрөг байгаа нь активын 74.9 хувьтай, цэвэр зээл 81.4 тэрбум төгрөг байгаа нь активын 72.3 хувьтай тус тус тэнцэж байна. Тайлант улиралд нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс

0.9 пунктээр өсөж 5.5 хувь болсон байгаа нь салбарын хэмжээнд чанаргүй зээлийн хэмжээ зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр тогтоосон дээд хэмжээнээс хэтэрсэн байна.


Зураг 22. Зээлийн багцын өөрчлөлтийг харьцуулж харуулбал



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 68.1 тэрбум төгрөг буюу нийт эх үүсвэрийн 60 хувийг эзэлж байгаа ба үүнээс 64.9 тэрбум төгрөг буюу 95 хувь нь хугацаатай хадгаламж, 3.2 тэрбум төгрөг буюу 5 хувь нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 23. Салбарын хэмжээгээр нийт хадгаламжийн өсөлт




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант улиралд гишүүдийн хувь хөрөнгийн хэмжээ 12.2 тэрбум төгрөг байгаа нь нийт эх үүсвэрийн 10.5 хувийг эзэлж байна.

ХЗХ-дын нийт орлого өмнөх оны мөн үеэс 2.9 тэрбум төгрөгөөр буюу 13.6 хувиар өсөж 24.7 тэрбум төгрөгт,

нийт зардлын хэмжээ 20.9 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.4 тэрбум төгрөгөөр буюу 12.8 хувиар өссөн байна. Салбарын ашгийн хэмжээ 3.8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 585,499.3 мянган төгрөгөөр буюу 18.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 24. Ашигт ажиллагаа



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

ХЗХ нь гишүүддээ зээл, хадгаламжийн үйлчилгээ үзүүлэхээс гадна санхүүгийн түрээс, төслийн санхүүжилт, цахим төлбөр тооцоо, даатгалын төлөөлөгч, мөнгөн гуйвуулгын болон хуримтлалын сан үүсгэх, удирдах зэрэг үйлчилгээнүүдийг эрхэлдэг.

2016 онд ХЗХ-дын тоо өмнөх оноос 10.7 хувиар, гишүүдийн тоо 18.0 хувиар, нийт активын хэмжээ 15.8 хувиар тус тус өссөн байна. Нийт активын болон

зээлийн хэмжээ өсөж банкны салбарт эзлэх хувь нь тус бүр 0.1 хувиар өссөн нь “Бичил бизнесийг дэмжих ядуурлыг бууруулах Нийслэлийн хөтөлбөр”-т 123 ХЗХ хамрагдсантай холбоотой бөгөөд төсөл хөтөлбөрөөс авсан зээлийн хэмжээ 15.5 тэрбум төгрөгт хүрсэн байна. Мөн ХЗХ-ны салбарын нийт активын хэмжээ 2016 оны II улирлаас эхлэн 100 тэрбум төгрөгийг даваад байгаа нь салбарын хувьд анхны тохиолдол юм.

# 2

## ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Хорооны эрх зүйн байдлын тухай хууль, бусад хуулиудад заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд бодлого зохицуулалт, бүртгэл зөвшөөрөлтэй холбоотой журам,

заавар, тогтоолын төслүүдийг боловсруулан Хорооны хуралдаанаар тухай бүр хэлэлцүүлэн батлуулж ажиллалаа.

## 2.1. БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ

Хорооны 2016 оны 261 дүгээр тогтоолоор баталсан бүтцээр салбарыг тодорхойлох газрууд нь бодлого зохицуулалт, бүртгэл зөвшөөрлийн гэсэн чиг үүрэгтэйгээр зохицуулалттай байгууллагуудын тогтвортой хөгжих боломж, стандартыг нь сайжруулан нэгдсэн бодлогоор дэмжин ажиллаж байна.

### 2.1.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ

Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн хөгжлийг дэмжих, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, оновчтой, үр дүн бүхий зохицуулалтын орчныг бий болгох зорилтын хүрээнд үнэт цаасны зах зээл дэх мэргэжлийн оролцогч болон хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаатай холбоотой нийт зургаан дүрэм журмыг шинээр боловсруулж, таван журамд холбогдох нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Үнэт цаасны зах зээлд санхүү, хүний нөөц, техник программ хангамжийн хувьд чадавхтай мэргэжлийн зуучлагч компаниудыг бий болгох, санхүүгийн зуучлалын чанарыг сайжруулах зорилгоор үнэт цаасны зах зээл дэх зохицуулалттай этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг эдийн засаг болоод ҮЦК–иудын үйл ажиллагааны нөхцөл байдалтай уялдуулан нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Ингэснээр олон улсын стандартад нийцсэн төлбөр, тооцооны системийг бий болгох /DVP загвар буюу төлбөрийн эсрэг нийлүүлэлт/ загварыг нэвтрүүлэх, төлбөр, тооцооны T+2, зсхүл T+3 горимд шилжих болон ҮЦК–иудын дундын төлбөрийн баталгааны сан байгуулагдах боломж, нөхцөл бүрдүүлэх, улмаар үнэт цаасны зах зээлийн арилжаа, хөрвөх чадварын түвшнийг нэмэгдүүлэхэд ач холбогдол бүхий алхам болсон.

Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэгдсэн биржийн тогтолцоог бүрдүүлэх зорилтын хүрээнд төрийн холбогдох байгууллага, “Монголын хөрөнгийн бирж” ХК, “Монголын үнэт цаасны бирж” ХХК, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК болон

мэргэжлийн оролцогч, дэд бүтцийн байгууллагуудын хооронд 2 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, энэ хүрээнд эхний ээлжинд биржүүдийн арилжааны тооцоог нэгдсэн журмаар явуулах тал дээр нэгдсэн шийдэлд хүрсэн бөгөөд мэргэжлийн оролцогч, хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх, гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалах механизмыг бүрдүүлэх чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлсэн.

Хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, хөрөнгийн зах зээл дэх гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын оролцоог нэмэгдүүлэх, хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан байгуулагдах нөхцөлийг сайжруулах, улмаар бодит эдийн засгийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл сайжруулах үндсэн чиглэл”–д Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн нэмэлт өөрчлөлт оруулах, Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хамтын санхүүжилтийн тухай, Хөрөнгө оруулагчийг хамгаалах сангийн тухай, Эрдэс баялгийн биржийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах саналыг тусгуулсан. Энэ ажлын хүрээнд бусад орны хууль эрх зүйн орчны талаарх судалгааны ажлыг эхлүүлж, дээрх хуулийн төслүүдийн танилцуулга, үзэл баримтлал, үндэслэлийг төрийн холбогдох байгууллага болон мэргэжлийн оролцогчдын төлөөллийг хамруулсан ажлын хэсгийг байгуулан хамтран ажиллах замаар холбогдох хуулийн төслийг боловсруулж байна.

УИХ–ын 2016 оны 11 дүгээр сарын 24–ний өдрийн 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”–ийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөнд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх талаар тодорхой бодлогын чиглэлүүдийг тусгуулж, нарийвчилсан төлөвлөгөөний дагуу холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллалаа.

УИХ–ын Эдийн засгийн байнгын хороо (ЭЗБХ)–нд 2016 оны 11 дүгээр сарын 22–ны өдөр “Хөрөнгийн

зах зээлийн нөхцөл байдал, цаашдын төлөв" сэдэвт танилцуулга, Хорооны үйл ажиллагааны тайлан болон бусад бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлсэн холбогдох арга хэмжээний талаар танилцуулсан. Мөн Хөрөнгийн зах зээлийн хөгжлийг олон улсын түвшинд хүргэх, түүний эдийн засагт гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц болон хууль эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төслийн хүрээнд боловсруулагдсан "Capital market strategy"–стратегид үндэслэн "Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг 2022 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр" дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулсан.

## 2.1.2. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛ

Даатгалын эрх зүйн орчныг сайжруулах, Хувийн тэтгэврийн даатгалын тухай болон Тариалангийн даатгалын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж, санал өгөх, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр ажиллав.

Хорооны 2016 оны 105 дугаар тогтоолоор батлагдсан "Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журам"–ын холбогдох маягыг нэгдсэн санхүүгийн мэдээллийн программ "Фин-А"–д нэвтрүүлснээр ердийн даатгалын компаниудын төлбөрийн чадварын зохистой харьцааны тайланг цахим хэлбэрээр хүлээн авч эхлэв.

Монголын даатгагчдын холбоо, Монголын зуучлагчдын холбоо болон Монголын хохирол үнэлэгчдийн холбооноос зохион байгуулдаг сургалтын үйл ажиллагаанд чанарын шалгалтыг хийв.

2016 онд Даатгалын зах зээлийн хууль эрх зүйн орчныг сайжруулах, зохистой зохицуулалтыг бий болгох чиглэлээр дараах журмуудыг шинэчлэн боловсрууллаа. Үүнд:

- Хорооны 50 дугаар тогтоолоор "Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам"–ыг шинэчлэн батлав.
- Хорооны 48 дугаар тогтоолоор "Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам"–ыг шинэчлэн батласанаар бүртгэл зөвшөөрлийн зохицуулалтын орчинг сайжрууллаа.

- Хорооны 49 дүгээр тогтоолоор журам, дансны жагсаалтыг шинэчлэсэнээр 2015 онд Сангийн сайд, Хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар", "Санхүүгийн тайлангийн маягт, тодруулга" зэрэгт нийцүүлэх үүднээс даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчдоос авах зарим санхүүгийн нэмэлт тайлангийн маягтад өөрчлөлт оруулах, нэгдсэн санхүүгийн тайлангийн бүртгэлийг шинэчлэв.
- Хорооны 70 дугаар тогтоолоор "Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"–ыг шинэчлэн баталсан.

Мөн эдийн засаг, бизнесийн орчны нөхцөл, даатгалын компаниудын санхүү, төлбөрийн чадварын байдлыг харгалзан Хорооны 2012 оны "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 355 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулж, дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлэх хугацааг 2018 оны 6 дугаар сарын 30–ны өдөр хүртэл сунгалаа.

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл бүртгэлийн журам, зааварт хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд 10 хувиас доош өөрчлөлт орох тохиолдолд Хороонд мэдэгдэж, бүртгүүлж байхаар Хорооны 407 дугаар тогтоолоор батлагдсан журамд нэмэлт өөрчлөлтийг оруулав.

Хорооны 235 дугаар тогтоолоор "Сайн дурын даатгалын хэлбэр"–г нэмэлт өөрчлөлт оруулснаар давхар даатгалын хэлбэрийг нэмэлтээр оруулж шинэчлэв. Хорооны 202 дугаар тогтоолоор "Даатгал, даатгалын мэргэжлийн оролцогчийн зарим журам, зааварт өөрчлөлт оруулах" тухай тогтоолоор хэд хэдэн журмуудын зүйл, заалтад нэмэлт өөрчлөлтийг тус тус хийлээ.

Орон сууцны ипотекийн зээлдэгчийг хүртээмжтэй, оновчтой хэлбэрээр даатгалд хамруулах санал боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох шийдвэрийг гаргуулав.

### 2.1.3. БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГА

ББСБ–уудын үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлэх, үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг хөнгөвчлөх, зохицуулалтын олон баримт бичгүүдийг нэгтгэх зорилгоор Хорооны 71 дүгээр тогтоолоор "Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам, заавар"-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмаар ББСБ–уудыг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан 3 ангилж, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгоход тавигдах нөхцөл шаардлагуудыг нарийвчлан тодорхойлж, зохицуулалтын хэм хэмжээг тогтоосон.

ББСБ–ын өөрийн хөрөнгө, эх үүсвэрийн зөв оновчтой бүтцийг бий болгох, эрсдэл даах чадварыг сайжруулах зорилгоор Хорооны 147 дугаар тогтоолоор "Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам"-ыг шинэчлэн баталж, Хорооны 269 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус журмаар ББСБ–д мөрдөх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг эрхлэх үйл ажиллагааны төрлөөс хамааруулан ялгавартай тогтоож тайлан мэдээг нарийвчлан гаргахаар зааж өгсөн.

Салбарын тогтвортой байдлыг хангах, өрсөлдөх чадвар болон эрсдэл даах чадварыг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх, үйлчилгээний өртгийг бууруулах, санхүүгийн хүртээмжийг дээшлүүлэх бодлого, зохицуулалтын хүрээнд Хорооны 72 дугаар тогтоолоор үйл ажиллагааны төрөл тус бүрээр хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчилэн тогтоож 2017 оны 01 дүгээр сарын 01–ний өдрийн дотор шинээр тогтоосон хэмжээнд хүргэхээр заасан бөгөөд нийт ББСБ–уудын 96 хувь нь тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн 271 дүгээр тогтоолоор ББСБ–ын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг шинэчлэн тогтоож, тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ–уудын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тодорхой хугацаанд үе шаттайгаар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

### 2.1.4 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

ХЗХ–ны салбарын чиг хандлагыг тодорхойлох, Хорооноос ХЗХ–дод авч хэрэгжүүлж буй бодлого, МХЗХҮХ–ны үйл ажиллагаа, АХБ болон Нийслэлээс хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох зорилгоор нийт ХЗХ–дыг хамруулсан судалгаа хийсэн.

Судалгаанд АХБ–наас хэрэгжүүлсэн төсөлд 83 ХЗХ, нийслэлийн төсөл хөтөлбөрт хамрагдсан 104 ХЗХ оролцсон байна. Салбарт хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн үр дүнг авч үзэхэд төсөл, хөтөлбөрүүд нь салбарт эерэг нөлөөлөл үзүүлж нийгэм дэх ХЗХ–ны нэр хүндийг нэмэгдүүлж, эх үүсвэрийг нэмэгдүүлсэн гэж дүгнэсэн байна.

ХЗХ–ны тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 д заасан тогтворжилтын сан байгуулж, санхүүгийн тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх, 55 дугаар зүйлийн 55.1–д заасан хоршооны гишүүдийн хадгаламж даатгалтай байна гэсний дагуу тэдгээрийг холбогдсон харилцааг зохицуулахаар АХБ–ны төслийн санхүүжилтээр гадаад, дотоодын зөвлөхүүдтэй хамтран ажиллаж байна.

Тогтворжилтын сан нь санхүүгийн байгууллагуудын дундаас байгуулагддаг бөгөөд санхүүгийн байгууллагын төлбөр гүйцэтгэх чадварыг хамгаалж, санхүүгийн байгууллагыг хамгаалах, системийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилготой юм.

Олон улсын хадгаламжийн даатгалын тогтолцооноос харахад ХЗХ–дын гишүүдийн мөнгөн хадгаламжийг даатгалд хамруулах нь эрх зүйн зохицуулалтын хувьд бие даасан хуультай бөгөөд зарим улс оронд тогтворжилтын сан нь хадгаламжийн даатгал, хамгаалалтын үйл ажиллагааг зэрэг хэрэгжүүлдэг байна.

## 2.2. БҮРТГЭЛ, ЗӨВШӨӨРӨЛ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд заасан бүрэн эрхий хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлаар тайлант хугацаанд дараах шийдвэрүүдийг гаргажээ.

Үнэт цаасны салбарт шинээр хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргасан 4 компани, 5 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 1 хөрөнгө итгэмжлэн удирдах компани, 8 үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх аудитын компани, 4 үнэт цаасны зах зээлд оролцогчид үйлчилгээ үзүүлэх хуулийн компанид тусгай зөвшөөрөл олгосон ба дараах зөвшөөрөл, эрхийг бүртгэжээ.

### Хүснэгт 10. Зөвшөөрөл, эрхийн тоо /Үнэт цаас/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Эрх бүхий албан тушаалтныг томилох	9
2	Оноосон нэрийг өөрчлөх	3
3	Салбар нээн ажиллуулах зөвшөөрөл	1
4	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	16

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Даатгалын салбарт даатгалын байгууллагад аудит хийх эрхийг 7 компанид, 5 компанид даатгалын хохирол үнэлэгчийн, 3 компанид даатгалын зуучлагчийн тусгай

зөвшөөрөл, даатгалын зуучлагч компанийн 28 салбарт зөвшөөрөл олгосон ба дараах зөвшөөрөл, эрхийг бүртгэжээ. Үүнд:

### Хүснэгт 11. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл эрхийн тоо /Даатгал/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Эрх бүхий албан тушаалтныг томилох	25
2	Салбарын зөвшөөрлийг хүчингүй болгох	5
3	Салбар нээн ажиллуулахыг зөвшөөрөл	31
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	149
5	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүчингүй болгох	405
6	Даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл олгох	28
7	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах	6
8	Хувьцаа эзэмшигчдийн бүтэцэд өөрчлөлт оруулах	9

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нийт 72 компанид шинээр олгон, 4 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг бүхэлд нь хүчингүй болгон, 1

компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээж дараах зөвшөөрөл, эрхийг бүртгэжээ. Үүнд:

## 2016 Үйл ажиллагааны тайлан

### Хүснэгт 12. Зөвшөөрөл, эрхийн тоо /ББСБ/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Оноосон нэрийг өөрчлөх	6
2	Салбар нээн ажиллуулах зөвшөөрөл олгох	9
3	Санхүүжилтийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох	1
4	Хоёрдогч өглөгөөр эх үүсвэр татахыг зөвшөөрөл олгох	2
5	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах	170

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Нийт 34 ХЗХ–нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгон, 2 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 7 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгон, 48 ХЗХ–ны тусгай зөвшөөрлийг сунгах асуудлыг шийдвэрлэсэн ба дараах зөвшөөрөл эрхүүдийг бүртгэсэн байна.

### Хүснэгт 13. Зөвшөөрөл, эрхийн тоо /ХЗХ/

№	Зөвшөөрөл эрхийн нэр	Тоо
1	Төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох	9
2	Санхүүгийн түрээсийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл олгох	1
3	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох	1
4	Салбарын зөвшөөрөл олгох	1

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Санхүүгийн зохицуулах хороо нь 2016 оны жилийн эцсийн байдлаар хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд банкнаас бусад санхүүгийн салбарт үйл ажиллагаа

эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрхийг нийт 2017 байгууллага хуулийн этгээд, 3741 иргэнд олгоод байна.



## 2.3. ХЯНАЛТ ШАЛГАЛТ

Хороо нь холбогдох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд зохицуулалтад хамаарагдах нийт 302 ХК, 62 ҮЦК, 17 даатгалын компани, 40 даатгалын зуучлагч компани, 31 даатгалын хохирол үнэлэгч компани, 518 ББСБ болон 280 ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд зайнаас болон газар дээрх хяналт шалгалтыг хийж, илэрсэн зөрчил дутагдалд хууль тогтоомжид заасан арга хэмжээ авч, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлээ.

Тус Хорооны зохицуулалтын хүрээний байгууллагын тоо жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа, төсөв санхүүгийн хүндрэлтэй байдлаас болоод орон нутагт хяналт шалгалт хийгдэхгүй байгаа, хүний нөөц хязгаарлагдмал зэрэг шалтгааны улмаас хамгийн бага зардлаар, үр дүнтэй хяналт шалгалтыг зохион байгуулах шаардлагын улмаас эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэхээр ажиллаж байна. Хяналт шалгалтыг зайны болон газар дээрхи хяналт шалгалт гэсэн хэлбэрээр зохион байгуулж ажиллалаа.

**Зайны хяналт шалгалт:** Тус Хорооны зохицуулалтад хамаарах этгээдүүд үйл ажиллагааны ба мэдээллийн төрлөөсөө хамаараад санхүүгийн тайлан, мэдээгээ сар, улирал, жилээр ирүүлдэг ба ирүүлсэн тайланг хүлээн авч, хянан, баталгаажуулдаг. Баталгаажуулсан тайлан мэдээнд үндэслэн зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадвар, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт, бусад шаардлага, шалгуурт зайнаас хяналт тавьж ажиллалаа. Фин-А системийн хугацааны цуваа бүхий мэдээллийн санг зохицуулалтын байгууллагуудын 2015 оны 4 дүгээр улирал, 2016 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн болон нэмэлт тайлангийн тоон мэдээллээр нэмэгдүүлэн бүрдүүлсэн.

Зайны хяналтаар зохицуулалтын байгууллагууд нь жилийн эцсийн санхүүгийн тайланг Хорооноос олгосон зөвшөөрөл бүхий аудитын компаниар хянуулаагүй, санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль, журмаар тогтоосон хугацаанаас хоцроож ирүүлсэн эсхүл ирүүлээгүй, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг мөрдөж ажиллаагүй зэрэг нийтлэг зөрчил илэрсэн. Зайны хяналтаар илэрсэн зөрчилд хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд арилгуулах арга хэмжээг

авсан ба тайлангийн хариугаар үүрэг даалгавар өгөх, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэх, газар дээрх шалгалтын хуваарьт оруулах болон торгох, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг арга хэмжээг авч ажилласан.

**Газар дээрх хяналт шалгалт:** Тайлант хугацаанд нийт 238 аж ахуйн нэгж, байгууллагыг хамарсан газар дээрх шалгалтыг хийсэн байна. Үүнд:

**Үнэт цаасны хяналтын чиглэлийн хүрээнд:** Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой хамтран 60 ҮЦК-д газар дээрх үзлэгийг хийж гүйцэтгэсэн. Уг үзлэгт хамрагдсан ҮЦК-иудын хувьд программ хангамжийн хувьд бүрэн шийдэгдээгүй, холбогдох дүрэм, журмын дагуу шаардлагатай боловсон хүчин хангалтгүй, Хорооноос тавьсан хувь нийлүүлсэн хөрөнгийн шаардлагыг хангаагүй зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн. Мөн тэдгээр компаниудын зүгээс хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх чиглэлээр санал бодлоо илэрхийлсэнийг Хороо холбогдох бодлого, шийдвэртээ тусган ажиллалаа.

Мөн жижиг хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол болон зайны хяналтын дүгнэлтэд үндэслэн нэр бүхий ХК-иудад газар дээрхи хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. Хувьцаат компаниудын хувьд хувьцаа эзэмшигчдийн хоорондын маргаан, үл ойлголцлоос болж хувьцаа эзэмшигчдийн хурлаа хийж чадахгүйд хүрэх, эд хөрөнгийн маргаан зэрэг асуудлууд байгаа нь газар дээрхи шалгалтаар илэрсэн бөгөөд зөрчил дутагдлыг арилгах талаар тухайн компаний төлөөлөн удирдах зөвлөл болоод бусад байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, холбогдох хуулийн дагуу хариуцлага ногдуулж ажиллалаа.

**Даатгалын хяналтын чиглэлийн хүрээнд:** Даатгуулагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол, зайны хяналтын дүгнэлт болон хяналт шалгалтын төлөвлөгөөнд үндэслэн нэр бүхий 6 даатгалын компани, Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаанд тус тус төлөвлөгөөт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар Хороонд бүртгүүлээгүй даатгалын бүтээгдэхүүнийг борлуулсан, хаяг байршлаа Хороонд бүртгүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн журам, заавар зөрчсөн зэрэг нийтлэг зөрчил дутагдал илэрсэн бөгөөд зөрчил дутагдлыг арилгах талаар тухайн компаний төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага

болоод бусад холбогдох байгууллагуудад хугацаатай үүрэг даалгавар өгч, хуулийн дагуу хариуцлага ногдуулж ажиллалаа.

**Банк бус санхүүгийн байгууллагын чиглэлийн хүрээнд:** Тайлант хугацаанд нийт 123 ББСБ–д газар дээрх хяналт шалгалт хийгдсэн бөгөөд үүнээс 117 нь санхүүгийн үйл ажиллагаан дахь газар дээрх шалгалт, 6 ББСБ–д ажлын байрны газар дээрх үзлэг болно. Шалгалтаар ББСБ–ын хөрөнгө хувьцаа эзэмшигчдийн дансанд байршсан, бэлэн мөнгөний үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан зэрэг нийтлэг зөрчил илэрсэн бөгөөд илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг арилгах даалгаврыг тухай бүр өгч ажилласан. Цагдаагийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллийн дагуу нэр бүхий 7 ББСБ–д нууцын зэрэглэлтэй шалгалтыг хийлээ.

**Хадгаламж зээлийн хоршооны чиглэлийн хүрээнд:** НЗДТГ–ын Хөдөлмөр эрхлэлтийн газартай хамтран “Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөр”–ийг хэрэгжүүлж байгаа 141 ХЗХ–ны үйл ажиллагаанд “Бичил бизнесийг дэмжих нийслэлийн сан”–аас санхүүжүүлсэн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, холбогдох журам, зааврыг хэрхэн биелүүлж байгаад

үнэлгээ өгөх зорилгоор хяналт–шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээнд хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтын дүнгийн нэгтгэл, үнэлгээг гарган, цаашид авах арга хэмжээний саналыг Нийслэлийн удирдлагуудад албан бичгээр хүргүүлсэн. Үйл ажиллагааг нь сайжруулах шаардлагатай ХЗХ–дод Улсын байцаагчийн албан шаардлагаар болон шалгалтын тайлангаар үүрэг даалгавар өгч, биелэлтийг тооцон ажилласан.

**Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр:** Монголбанкны ерөнхийлөгч, Хорооны даргын хамтарсан тушаалаар баталсан удирдамжийн дагуу 11 байгууллагын /ерөнхий боловсролын сургууль, зочид буудал, үнэт эдлэлийн дэлгүүр/ үйл ажиллагаанд газар дээрх хэсэгчилсэн шалгалтыг хийсэн. Газар дээр хийгдэж байгаа шалгалтаар байгууллагууд төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйлгээ хийж буй эсэхэд, мөн гэрээнүүдийн үнэлгээ, хураамж үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэгдсэн эсэх зэрэгт хяналт тавьж ажиллалаа. Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийг зөрчсөн нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудад зөрчлийг арилгах үүрэг өгч, биелэлтийг хангуулан ажиллав.

# 3

САНХҮҮГИЙН ЗАХ  
ЗЭЭЛИЙН ТОГТВОРТОЙ  
БАЙДЛЫГ ДЭМЖИХ

## 3.1. САНХҮҮГИЙН ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГ ДҮҮЛЭХ

Санхүүгийн үйлчилгээг боломжийн өртгөөр хүргэх таатай орчныг бүрдүүлэх, санхүүгийн үйлчилгээний нэгжийн өртгийг бууруулах, шинэ технологийн хэрэглээг бий болгох бодлогыг боловсруулах, тогтвортой, бүрэн, хүртээмжтэй санхүүгийн салбарыг бий болгох зорилгыг хангах зохицуулалтын бүтцийг бий болгох, бага, дунд орлоготой иргэдэд санхүүгийн салбарын үйлчилгээг хүргэх зорилгоор үйлчлүүлэгчдийн хамгаалах, эрхээ хэрэгжүүлэх боломжийг бий болгох, мэдээлэл цуглуулах, шинжлэх замаар санхүүгийн хүртээмжийн хандлагын өөрчлөлтийг бий болгон санхүүгийн хүртээмжийн бодлогыг боловсруулах нь өнөөгийн даяаршлын чухал зорилт болж байна.

### 3.1.1. ИРГЭДИЙН САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Банкнаас бусад санхүүгийн зах зээлийн талаар олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтарч дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:

Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)–аас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд олон нийтэд анх удаа хувьцаагаа санал болгон гаргах /IPO/ болон давхар бүртгэлийн талаарх семинарыг үнэт цаас гаргагч болон мэргэжлийн оролцогч байгууллагууд, сонирхсон иргэдийг хамруулан зохион байгуулсан;

Мөн хөрөнгийн зах зээлийг олон нийтэд сурталчлах, зах зээлийн оролцогчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах ажлын хүрээнд МҮЦАЭХ, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)–тай хамтран “Нэг зорилго–Нэг шийдэл” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан;

МҮЦАЭХ–той хамтран “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох, аттестатчлах сургалт”–ыг зохион байгуулж, 52 иргэнд үнэт цаасны зах зээлд үнэт цаасны зуучлал, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрх олгосон;

Хөрөнгийн зах зээлтэй холбоотой мэдээллүүд болох хувьцаа, ЗГҮЦ, компанийн өөрийн хэрэгсэл, үүсмэл үнэт цаастай холбоотой анхан шатны мэдлэг олгох мэдээллийг боловсруулан Монголбанкны цахим хаягт байршуулав.

Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр Дэлхийн банкны олон талт хамтын ажиллагааны техникийн туслалцааны төсөл, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/–т хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн болон хөрөнгө оруулалтын суурь мэдлэг олгох, хөрөнгө оруулалтын үндэсний цахим платформыг үүсгэх чиглэлд дэмжлэг үзүүлэх хүсэлтээ, нарийвчилсан төлөвлөгөөг гаргасан бөгөөд Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/–ээс дээрх ажлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон.

- Дэлхийн банктай хамтран даатгалын компаниудын ажилтнуудад зориулсан “Мэдлэг олгох” 3 өдрийн сургалт;
- МОН/004 төсөлтэй хамтран даатгалын компаниудын актуар, нөөцийн сан хариуцсан ажилтнуудад зориулсан сургалт;
- МОН/004 төсөлтэй хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт;
- Сангийн яам, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгагчдын холбоо, БНСУ–ын Хохирол үнэлгээчдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Даатгалын тогтолцоо, албан журмын даатгал, хохирол үнэлгээ” сэдэвт сургалт;
- Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан “Эрсдэлд суурилсан хяналт шалгалт” сэдвийн дагуу олон улсын даатгалын үндсэн зарчим, эрсдэлийн ангилал болон үнэлгээний сургалт;
- Монголын актуарчдын нийгэмлэг, Монголын даатгагчдын холбоотой хамтран зохион байгуулсан Актуарчийн сургалт;
- Даатгалын танин мэдэхүйн өдөрлөг;
- Монголын даатгагчдын холбоо, Актуарчдын нийгэмлэг, Монголын даатгалын зуучлагчдын

холбоо, Хөгжлийн банк, даатгагч нартай хийсэн журам, зааврын төсөл болон даатгалын бүтээгдэхүүн, хохирлын нөхөн төлбөрийн талаарх уулзалт, хэлэлцүүлэг;

- Замын цагдаагийн газар, даатгалын мэргэжлийн холбоотой хамтарсан Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, шуурхай албаны үйл ажиллагааны талаарх уулзалт, хэлэлцүүлэг;
- Дэлхийн банкны зөвлөхүүд, даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй даатгалын компанийн удирдлагууд болон Хорооны удирдлага, Даатгалын газар, Хяналт шалгалт, зохицуулалтын төлөөллийг оролцуулсан дугуй ширээний хэлэлцүүлэг;

Хорооны нийгмийн маркетингийн бодлогыг хэрэгжүүлэх болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх ажлыг сайжруулж, тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд зориулан хэвлэл мэдээллийн байгууллагуудтай өргөн хүрээнд хамтран ажиллаж мэдээ мэдээлэл түгээсэн.

Иргэдийн санхүүгийн зах зээлийн мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй хүргэснээр иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн зах зээлд оролцох оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор “Санхүүгийн зах зээл” сэдэвт сургалтыг 40 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын сэтгүүлчдийг оролцуулан зохион байгуулав.


“Санхүүгийн зах зээлийн хөгжил үндэсний форум-2016”, Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг /AFI/-ийн Жижиг дунд үйлдвэрийн санхүүгийн ажлын хэсгийн /SMEFW-G/-ийн олон улсын ээлжит чуулган, Монгол Улсын ХЗХ-ны салбарын 20 жилийн ойг тохиолдуулан МХЗХҮХ-той хамтран Монголын ХЗХ-дын “Хөгжлийн төлөө хамтдаа” үндэсний хоёрдугаар форумыг тус тус зохион байгууллаа. Мөн Хорооны орон нутаг дахь төлөөлөгчдөд зориулсан сургалтыг хэсэгчилсэн байдлаар 3 удаа хийлээ.

Хороо нь хөтөлбөрт тусгагдсан хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, өөрийн зохицуулалтад хамаарагдах өөрийгөө зохицуулах болон мэргэжлийн байгууллагуудыг татан, хөрөнгө оруулалт, даатгалтай холбоотой мэдээллийг цахим хуудсанд байршуулах ажлыг гүйцэтгэхээр үүрэг хүлээсэн.

### 3.1.2. ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ, ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ

Санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй Хорооны зохицуулалтын салбар болох үнэт цаас, даатгал, ББСБ, хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс 2016 оны жилийн эцсийн байдлаар нийт 442 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд 2015 онтой харьцуулахад 14 хувиар өссөн байна.

Зураг 25. Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдол /салбар тус бүрээр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Тайлант хугацаанд ирсэн нийт өргөдөл гомдлын 46 хувийг зөвхөн даатгалтай холбоотой ирсэн өргөдөл гомдол эзэлж байна. 2016 онд ирсэн өргөдөл, гомдлын тоог 2015 онтой харьцуулахад ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 41%, ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 82%, даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 9%, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол 5.3%-иар тус тус нэмэгдсэн.

Өөрөөр хэлбэл, ББСБ, ХЗХ-той холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо өмнөх жилийнхээс эрс өссөн, харин үнэт цаас, даатгалын салбартай холбоотой өргөдөл гомдлын тоо 2015 онтой харьцуулахад харьцангуй тогтвортой байсан гэж үзэж болохоор байна.

Үнэт цаасны салбарт ирсэн өргөдөл, гомдол: 2016 онд үнэт цаасны зах зээлийн зохицуулалтын байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой нийт 168 өргөдөл, гомдол ирсэн.

Зураг 26. Үнэт цаасны өргөдөл, гомдол /төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


Зөвшөөрөлгүй арилжаатай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлын нийт үнэт цаасны чиглэлээр ирүүлсэн өргөдөл гомдолд эзлэх хувь 2015 онд 63.5% байсан бол 2016 онд 66% байгаа нь энэ төрлийн өргөдөл гомдлын тоо буурах хандлагагүй байгааг харуулж байна.

Энэхүү зөвшөөрөлгүй арилжаалагдсан гэх үйлдэл нь 1996 оноос 2005 оны хооронд хийгдсэн бөгөөд сүүлийн жилүүдэд иргэд хувьцааны талаар тодорхой ойлголттой болж буй, мөн Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ХК зэрэг байгууллагуудаас цэнхэр, ягаан тасалбартай холбоотой мэдээллийг олон нийтэд түгээх болсон, ЗГ–аас иргэдэд “Эрдэнэс таван толгой” ХК–ийн 1072 хувьцааг олгохтой холбогдуулан данс нээх, дансаа шалгах болсон зэргээс энэ төрлийн өргөдөл гомдлын тоо өссөөр байна.

Энэ салбартай холбоотой бусад төрлийн өргөдөл, гомдлын хувьд хувьцаат компанийн ногдол ашиг, хувь, хувьцаа эзэмшигчдийн хурлын талаар, мөн үнэт цаасны бүртгэл, болон тэдний үйл ажиллагаатай холбоотой гомдлууд тус тус ирсээр байгаа бөгөөд эдгээр гомдлуудын нийт үнэт цаасны салбарын өргөдөл гомдолд эзлэх хувь харьцангуй тогтвортой байна.

Даатгалын салбарт ирүүлсэн өргөдөл гомдол: Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 202 өргөдөл, гомдлыг Хороонд ирүүлсэн. Ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилан харуулбал:

Зураг 27. Даатгалын өргөдөл, гомдол /төрлөөр/




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2016 онд ирсэн өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлүүдээр ангилан харуулбал жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 36 хувь (2015 онд 35%) буюу хамгийн өндөр байх бөгөөд тээврийн хэрэгслийн даатгал 28 хувь (2015 онд 39%), харин даатгалын бусад асуудлууд үлдсэн хувийг эзэлж байна.

Жолоочийн болон тээврийн хэрэгслийн даатгалтай холбоотой өргөдөл, гомдлын тоо жилээс жилд өндөр байгаа шалтгаан нь энэ төрлийн даатгалын гэрээ нь нийт даатгалын гэрээний 60 орчим хувийг хамтран бүрдүүлдэгтэй холбоотой.

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдөл, гомдол: Тайлант хугацаанд ББСБ–ын үйл ажиллагаатай холбоотой нийт 31 өргөдөл, гомдол ирсэн байна. 2016 онд ирүүлсэн өргөдөл, гомдлыг 2015 онтой харьцуулбал 82.3 хувиар өссөн байна. Ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь харуулбал:

Зураг 28. ББСБ-ын өргөдөл, гомдол /төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо


ББСБ-ын салбарт 2016 онд ирүүлсэн өргөдөл, гомдлын 45%-ийг зээлийн гэрээ, зээлтэй холбоотой үйл ажиллагаа болон зээлийн хүүтэй холбоотой өргөдөл, гомдлууд эзэлж байна.

ББСБ-тай холбоотой өргөдөл гомдлын тоо 2016 онд өмнөх 2015 онтой харьцуулахад 82.3 хувь өссөн нь 2 үндсэн төрлийн өргөдөл, гомдлын тоо өссөнтэй шууд хамааралтай байна. Тухайлбал, зээлийн гэрээ, зээлтэй холбоотой үйл ажиллагаа болон зээлийн хүүтэй холбоотой өргөдөл, гомдлын тоо өмнөх онтой харьцуулахад 133.3 хувиар, зээлээ бүрэн төлж барагдуулсан зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлэн бүртгээгүйн улмаас хувь хүний зээлийн хувийн хэрэгт сөргөөр нөлөөлсөн гэх мэт зээлийн мэдээллийн сантай

холбоотой өргөдөл, гомдлын тоо 400 хувиар өссөн байна. Түүнчлэн, зээлээ бүрэн төлж барагдуулсан зээлдэгчдийн мэдээллийг зээлийн мэдээллийн санд тухай бүр шинэчлэн бүртгээгүйн улмаас хувь хүний зээлийн хувийн хэрэгт сөргөөр нөлөөлсөн гэх мэт асуудлуудыг холбогдох хууль, журмын дагуу хянан шийдвэрлэлээ.

ХЗХ-дын үйл ажиллагаатай холбогдуулан 41 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд өмнөх оны жилийн эцсийн байдалтай харьцуулбал 41.3 хувиар өссөн байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар ХЗХ-той холбоотой ирсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь харуулбал:

Зураг 29. ХЗХ-ны өргөдөл, гомдлыг /төрлөөр/



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо



Хадгаламж, зээлийн хоршооны чиглэлээр ирж буй өргөдөл гомдлын дийлэнх буюу 57.1 хувийг хоршооны удирдлага, сонгуультай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна. Энэ нь Нийслэлээс хэрэгжиж буй бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах төсөл хөтөлбөрийн хүрээнд Нийслэлийн хөдөлмөрийн газраас ХЗХ–дод өгч буй санхүүжилттэй холбоотойгоор ХЗХ–ны сонгуульт албан

тушаалтан болон гүйцэтгэх удирдлага, гишүүдийн хооронд санал зөрөлдөх, зээл олгохдоо зээлийн хүүг урьдчилан суутгадаг, барьцаа хөрөнгийн талаар өргөдөл, гомдлын тоо өссөн. Тухайлбал, энэ төрлийн өргөдөл, гомдол 2016 онд 2015 онтой харьцуулахад 50.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## 3.2. САЛБАРЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

Банкнаас бусад санхүүгийн салбарын нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтыг хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хүрээнд Монгол Улсын 18 хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

Мөн зохицуулалтын хүрээний байгууллагуудын үйл ажиллагаа, бүртгэл, тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олгох чиглэлээр Хорооноос баталсан 210 гаруй журам, дүрэм, заавар, аргачлалыг Хорооны тогтоол болон Хорооны даргын тушаалаар батлан мөрдүүлж байна. Эдгээр журмуудыг 2016 оны 7 дугаар сарын 01–нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинэчлэн батлах эрх зүйн нөхцөл байдал үүссэн.

Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд “Монгол Улсын Хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”–ийн төсөлд 17 хуулийн төслийг шинээр боловсруулах, шинэчилсэн найруулга хийх, нэмэлт өөрчлөлт оруулахаар санал хүргүүлж тусгуулсан. Санхүүгийн аливаа гүйлгээг жинхэнэ нэрээр нь гүйцэтгэх тухай, Хамтын санхүүжилтийн тухай, Эмнэлгийн мэргэжилтний хариуцлагын даатгалын тухай, Хуульчийн мэргэжлийн хариуцлагын албан журмын даатгалын тухай хууль, Хөрөнгө оруулагчийг

хамгаалах сангийн тухай гэх мэт шинэ хуулиудыг судлан боловсруулах судалгааны ажлыг эхлүүлээд байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 2016 оны 76 дугаар захирамжаар байгуулагдсан “Банк, санхүү, даатгалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, даатгал, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар санал дүгнэлт гаргах” үүрэг бүхий Ажлын хэсэгт орж ажиллан, “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”–ийн төслийг боловсруулж, ЗГ–ын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах үүрэг бүхий ажлын хэсгийг “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл”–өөс байгуулж ажиллалаа.

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл боловсруулах УИХ–аас байгуулсан ажлын хэсэгт ажиллаж байна.

Төрийн санхүүгийн бодлогын баримт бичгүүд тухайлбал Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Төрийн мөнгөний бодлогыг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Эдийн засгийг сэргээх хөтөлбөр, ЗГ–ын үйл ажиллагааны 2016–2020 оны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө зэрэгт холбогдох саналыг тусгасан ажлын хэсгүүдэд орж ажилласан.

# 4


## ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.1. БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Хорооны нэгжүүдийн чиг үүргийн давхардлыг арилгах, зардал хэмнэх, ачааллыг нягтруулах зорилгоор бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн. Ажлын албаны хуучин бүтцээр 7 газар, газрын орлогч дарга 3, 16 хэлтэс,

3 алба нийт 30 удирдах албан тушаалтан байсныг 2016 оны 8 дугаар сараас шинэ бүтцээр 7 газар, 4 хэлтэс, 2 алба нийт 16 удирдах ажилтантай болгон удирдлагын тоог 2 дахин бууруулсан.

Зураг 30. Бүтэц



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

## 4.2. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ажлын төлөвлөлт зохион байгуулалт, дээд газрын тогтоол шийдвэрийн биелэлтийг хангах чиглэлээр: Хороо 2016 онд 3 бүлгээр 123 ажил үйлчилгээ хийж гүйцэтгэхээр төлөвлөн ажиллав. Түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ, Байнгын хороод, ЗГ-ын нийт 15 тогтоол, шийдвэрийн 73 заалтын биелэлтийг гаргаж холбогдох Төрийн байгууллагуудад хүргүүллээ. 2016 онд Монгол Улсын шинээр буюу шинэчлэгдэн батлагдсан нэмэлт өөрчлөлт орсон Монгол Улсын хууль 374, УИХ-ын 121 тогтоолыг хүлээн авч Хорооны үйл ажиллагаанд шууд хамааралтай УИХ-ын 7 тогтоолд “Хяналтын карт” нээж биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

УИХ-ын ЭЗБХ-ны хуралдаанд “Хөрөнгийн зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын хандлага”-ын талаар танилцуулга хийв. Мөн 2013–2016 онуудад УИХ-аас гарсан шийдвэр, салбарын хуулийн хэрэгжилт, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгтгэн УИХ-ын Тамгын газарт хүргүүлсэн.

“Зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн 2014–2016 онд хэрэгжүүлэх дунд хугацааны хөтөлбөр” хэрэгжиж дууссантай холбогдуулан биелэлтийг 2016 оны 2 дугаар улирлын байдлаар гаргаж тайлагнасан.

Төрийн санхүүгийн бодлогын баримт бичгүүд болох “Монгол Улсын эдийн засаг-нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”, “Монгол Улсын ЗГ-ын үйл ажиллагааны 2016–2020 оны хөтөлбөр”, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” зэрэгт салбарын саналуудыг тусган батлуллаа.

Хорооны Ажлын албаны дэргэд байнгын ажиллагаатай орон тооны бус “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, “Өмч хамгаалах байнгын зөвлөл”, “Ёс зүйн хороо” ажиллаж байгууллагын архив албан хэрэг хөтлөлтийн ажилд хяналт тавих, өмч хөрөнгө хамгаалах, ажилтан албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

2016 онд Хороо нь төрийн санхүүгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, санал дүгнэлт гаргах, хууль тогтоомж боловсруулах, судалгаа хийх зэрэг чиглэлүүдээр УИХ,

ЗГ бусад төрийн байгууллагуудтай хамтарсан 27 ажлын хэсэгт орж ажиллажээ.

Хорооны хурал хуралдаан: 2016 онд Хорооны хуралдаан 17 удаа хуралдаж банкнаас бусад санхүүгийн салбарын 329 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хорооны хуралдаанаар салбарын хэмжээнд мөрдөгддөг хууль тогтоомжуудад нийцүүлэн 6 журам шинээр, 14 журам шинэчлэн, 7 журамд нэмэлт өөрчлөлт, 5 журамд өөрчлөлт оруулан баталж мөрдүүлэн 15 журам хүчингүй болгож 1 журам хэсэгчлэн хүчингүй болгожээ. Эдгээр журмуудыг мөрдүүлснээр бичил санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх, санхүүгийн зах зээлд оролцогчдод тавигдах шаардлагыг өндөржүүлэх, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, зах зээлийн эрсдэлийг бууруулах, үндэсний болон гадаадын хөрөнгө оруулагчдын зах зээлд оролцох сонирхлыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэв.

Сургалт: Хороо нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу эрх олгох сургалтыг даатгалын байгууллагад аудит хийх, хохирол үнэлэгчийн эрх, төлөөлөгчдийн эрх олгох, үнэт цаасны зах зээлд ажиллах хуулийн, аудитын, үнэлгээний компаниудад эрх олгох, мөн үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод арилжааны, зуучлалын, хөрөнгө оруулалтын, мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрх олгох сургалтуудыг мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулж ажиллалаа.

Хорооны ажилтнуудыг мэргэшүүлэх, чадавхжуулах сургалтын төлөвлөгөө”-ний дагуу салбарын мэргэшлийн чиглэлээр болон төрийн алба, хууль тогтоомж, ёс зүйн сэдвүүдээр 21 төрлийн сургалтыг зохион байгуулж, нийт ажилтнуудыг бүрэн хамруулсан.

Япон улсын ЗГ-ын буцалтгүй тусламжаар хэрэгждэг магистрын хөтөлбөрт хууль, олон улсын бизнесийн чиглэлээр 2, БНСУ-ын ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрт 1, Азийн актуарчдын нийгэмлэгийн тэтгэлэгт хөтөлбөрт 1 ажилтан хамрагдаж Актуарын магистрын чиглэлээр тус тус суралцахаар болсон.

Архив албан хэрэг хөтлөлт: Хороонд тайлант хугацаанд нийт 9998 бичиг 500 өргөдөл хүлээн авч шийдвэрлэн 3956 бичиг гадны байгууллагад илгээсэн байна. Нийт албан бичгийн эргэлт тоогоор 14454 бичиг, хуудсаар 213327,5 хуудас байна. Хоногийн албан бичгийн эргэлт тоогоор 57,4 бичиг, хуудсаар 846,5 хуудас байна.

Тайлант хугацаанд Хорооны архивт 12353 ширхэг хадгаламжийн нэгж хадгалагдаад байна. Хорооны архивын баримтаас байгууллага болон иргэдийн хүсэлт, дотоодын хэрэгцээнд 8662 хадгаламжийн нэгжээс хуулбар лавлагааг олгожээ.

*Хүснэгт 14. Баримт бичгийн эргэлтийн мэдээ*

Д/д	Хүлээн авсан бичиг, өргөдөл, архив	2016
1	Нийт албан бичгийн эргэлт тоогоор	14454
2	Нийт албан бичиг хуудсаар	213327,5
3	Хоногийн албан бичгийн эргэлт тоогоор	57,4
4	Хоногийн албан бичиг хуудсаар	846,5
5	Хорооны архивд байгаа хадгаламжийн нэгж	12353
6	Хадгаламжийн нэгжээс олгосон хуулбар лавлагаа	8662

*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

### 4.3. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Хороо нь гадаад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, зохицуулалтын болон хяналт шалгалтын үйл ажиллагаагаа олон улсын түвшинд хүргэх, мэдээлэл солилцох зорилгоор олон улсын санхүүгийн гурван байгууллагад гишүүнчлэгдэн гадаадын ижил төстэй долоон байгууллагатай 2 талт санамж бичгийн хүрээнд ажиллаж, 4 төсөл хэрэгжүүлж байна.

Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг (AFI)-ийн Жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн Ажлын хэсэг (SME Finance working group)-ийн VI чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулж ажиллав. Чуулга уулзалтаар Монгол Улсын санхүүгийн хүртээмжийн байдал, зорилго, тулгамдаж байгаа асуудал, Нийгэмлэгийн гишүүн орнуудад хэрэгжүүлж буй жижиг, дунд үйлдвэрийн санхүүгийн шинэчлэл, өөрчлөлтүүд, тэдгээрийн явц, санхүүгийн хүртээмжийн бодлого, түүний нэгдсэн мэдээллийн сан, цахим төлбөр тооцоог ашиглахад бодлого боловсруулагчийн үүрэг зэрэг асуудлыг хэлэлцэв.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түүгээр дамжуулан хөдөө аж ахуйн жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих, хөгжүүлэх, улмаар Монгол Улсад хөдөө аж ахуйн дэд бүтцийг бий болгох стратегийн зорилтыг тавьж байгаагийн хувьд шинээр байгуулагдах Хөдөө аж ахуйн санхүүгийн ажлын хэсэг /Agricultural finance working group/-ийг Хороо ахлан ажиллах санаачилгыг гаргалаа.

Хөрөнгийн зах зээлийн чадавхийг сайжруулах төслийн хүрээнд “Хувьцааг олон нийтэд санал болгох, давхар бүртгэл”, “Өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах”, “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх”, “Бодлогын зөвлөлийг идэвхтэй ажиллуулах”, “Хөрөнгийн зах зээлийг үе шаттайгаар хөгжүүлэх” “Хөрөнгийн зах зээлд бий болгох боломжит шинэ бүтээгдэхүүнүүд” сэдэвт 7 сургалт, үнэт цаасны компаниудыг хамруулсан 8 удаагийн сургалтыг Японы Олон улсын хамтын ажиллагааны агентлаг /JICA/-тай хамтран зохион байгуулав. Төслийн дадлагажих хөтөлбөрийн хүрээнд 1 ажилтныг Япон Улсын Санхүүгийн үйлчилгээний агентлагт 3 сарын сургалтад хамрууллаа.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд санхүүгийн системийн хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэсэн техник туслалцааны хүрээнд ОУВС-ын зөвлөхүүдтэй хамтран “Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын хэрэгсэл” журам боловсруулах ажлыг эхлүүлэв. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх “Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан”-ийн уулзалтыг зохион байгууллаа.

Дэлхийн банкны Олон салбарыг хамарсан техник туслалцааны төсөл /MSTAP/-ийн Ази, Номхон далайн санхүүгийн салбарын төлөөлөгчидтэй уулзсан олон удаагийн уулзалтаар Монгол Улсын санхүүгийн салбарын өнөөгийн байдал, УИХ, Засгийн газраас дэвшүүлж байгаа хөтөлбөр, Хорооны бодлого, зохицуулалтын төлөв, чиг хандлагыг танилцуулан, Олон салбарыг хамарсан техник туслалцааны 2 дахь шатны төслийг хэрэгжүүлэх чиглэлээр хэлэлцэв.

Азийн Хөгжлийн Банкны JFPR9152-MON “Ядуу иргэдэд чиглэсэн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх төсөл” нь 2016 оны 4 дүгээр сард албан ёсоор дууссан бөгөөд ХЗХ-ны гишүүдийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд хамруулах эрх зүйн орчинг бүрдүүлэх, тогтворжилтын үйлчилгээг эхлүүлэхэд туслалцаа үзүүлэхийг хүссэнээр АХБ-наас олон улсын болон үндэсний зөвлөх ажиллуулах, ХЗХ-дод сургалт, сурталчилгаа хийх чиглэлээр 360 мянган ам.долларын техникийн туслалцаа, буцалтгүй тусламж үзүүлэхээр АХБ, Хороотой төслийн баримт бичигт 2016 оны 3 дугаар сарын 11-ний өдөр 2 талаас гарын үсэг зурж 11 дүгээр сараас хэрэгжүүлж эхлээд байна.

Люксембургийн Хөгжлийн Агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн “Санхүүгийн салбарын чадавхийг бэхжүүлэх, сургалтын МОН/004” төсөл 2016 оны 6 дугаар сард албан ёсоор амжилттай дуусч төслийн тайланг гаргалаа. Уг төслийн Удирдах зөвлөлийн гишүүдтэй уулзаж МОН/004 төслийн хэрэгжилт болон төслийг үргэлжлүүлэх саналыг тавьснаар Олон улсын зөвлөхтэй цаашид хэрэгжих сургалт хөтөлбөрийн сэдвүүдийг хэлэлцэж 2017 онд хийгдэх нийт 40 өдрийн сургалтын хөтөлбөрийг баталлаа.

Хороо нь төрийн зорилт чиг үүрэг болон санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, зохицуулалтын салбаруудын мэргэжлийн холбоод, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай “Харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулан ажиллаж байна.

2016 онд Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоотой “Нэг зорилго-Нэг шийдэл” сэдэвт хэлэлцүүлэг, Сангийн яам, Албан журмын даатгагчдын холбоо, Монголын даатгагчдын холбоо, БНСУ-ын Хохирол үнэлгээчдийн холбоотой хамтран зохион байгуулсан “Даатгалын тогтолцоо, албан журмын даатгал, хохирол үнэлгээ” сэдэвт сургалт, Монголын актуарчдын нийгэмлэг, Монголын даатгагчдын холбоотой хамтран “Актуарчийн сургалт”, “Даатгалын танин мэдэхүйн өдөрлөг” зэрэг арга хэмжээнүүдийг хамтран зохион байгууллаа.

МҮЦАЭХ-ноос зохион байгуулж буй үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд Эрх олгох, аттестатчлах сургалтын чанарт үнэлэлт өгч сургалтын хөтөлбөр нь агуулгын хувьд Хорооноос тавьж буй шаардлагыг хангахгүй байгааг зөвлөн хөтөлбөрийг чиглэл тус бүрээр шинэчлэн боловсруулж, Мэргэшлийн зөвлөлөөр батлуулан, эрх олгох болон аттестатчилах сургалтыг шинэчлэгдэн батлагдсан хөтөлбөрийн дагуу зохион байгуулахыг анхааруулж ажиллалаа.

Хороо нь ахмад болон залуу үеийн залгамж холбоог батжуулах, ахмад ажилчдын мэргэжлийн дадлага, туршлагыг өвлүүлэх, залуу албан хаагчдад мэргэжлийн ур чадвар, хууль эрх зүй болон ёс зүйн зөв дадал эзэмшүүлэхэд илүү анхаарал хандуулан Хорооны ахмадын зөвлөлтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан үйл ажиллагааг нь тогтмолжуулж байна.

## 4.4. ТӨСӨВ, САНХҮҮ

Хорооны төсөв 2016 онд 2,713.6 сая төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулахад тухайлбал орон нутгийн зохицуулалттай хуулийн этгээдүүдэд хяналт шалгалт хийх, иргэдийн гомдол хүсэлтийн дагуу газар дээрх үзлэг хийх, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хууль тогтоомж таниулах зэрэг Хорооны үндсэн чиг үүргийн ажлуудыг хийх төсөв хүрэлцэхгүй нөхцөл үүсэж Сангийн яам, ЭЗБХ, Төсвийн байнгын хороонд төсвийн хүндрэлтэй асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт тавьсан. Улмаар 2016 оны 9 дүгээр сард хийсэн Монгол Улсын төсвийн тодотголоор Хорооноос тавьсан

хүсэлтийн зарим нэг зардлыг шийдвэрлэхээр 110.3 сая төгрөгийн төсвийг баталж, нийт 2,823.6 сая төгрөгийн санхүүжилтээр үйл ажиллагаагаа явуулсан.

Хороо нь 2016 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос 822.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөж, 1,190.9 сая төгрөгийг төвлөрүүлж 44.3% –иар давуулан биелүүлсэн. Мөн торгуулийн орлогоор 96.4 сая төгрөг, тэмдэгтийн хураамжийн орлогоор 50.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Хүснэгт 15. Төсвийн орлого ба зарлага гүйцэтгэлээр /сая төгрөгөөр/

Д/д	Төсөв	Дүн
1. Төсвийн орлого		
1	Улсын төсвийн санхүүжилтийн орлого	1,735.3
2	Үндсэн үйл ажиллагааны орлого	1,190.9
3	Тусламжийн сангийн орлого /АХБ/	172.6
4	Нийт орлогын дүн	3,102.1
5	Батлагдсан төсөв	2,823.6
2. Төсвийн зарлага		
6	Цалин, НДШ–ийн зардал	1,822.5
7	Байрны түрээс, байр ашиглалтын зардал	343.2
8	ОУ–ын байгууллагын гишүүний хураамж	142.7
9	Бараа үйлчилгээний бусад зардалд /төсөл хөтөлбөр/	172.6
10	Хангамж, бараа материал бусад зардал	194.7
11	Нийт дүн	2,675.5
12	Зардлын хэмжэлт	147.9

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Төсвийн зардлыг хэмнэх, ажлын давхардлыг арилгах, үр ашиггүй зардлыг бууруулах, хэмнэлтийн зарчмаар ажиллах УИХ–ын тогтоолын дагуу гадаад томилот, урсгал засварын зардлуудыг санхүүжүүлээгүй, бүтцийн өөрчлөлт хийснээр цалингийн зардал буурсан, олон улсын гишүүнчлэлийн хураамжийн урьдчилгаа төлөгдөөгүй зэргээс зардал хэмнэгдсэн.

Төсвийн ангилал зөрчсөн, зарлага хэтэрсэн зөрчил байхгүй Төсвийн тухай хууль, НББ–ийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон холбогдох тогтоол, заавар, журмуудыг биелүүлж ажилласан.

Шийдвэрлэх, анхаарах асуудлууд: Сүүлийн жилүүдэд санхүүгийн зах зээлийн хөгжил, хууль тогтоомжийн шинэчлэл зэрэгтэй холбоотой Хорооны зохицуулалтын хүрээ өргөжин тэлж байна. Үүнд:

- Санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулдаг компаниудын тоо эрс өссөнтэй уялдаатайгаар зах зээлд гарах шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл, үйлчлүүлэгч, хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн;

- Хороо нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Зээлийн батлан даалтын сангийн тухай, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай зэрэг 10 гаруй хуульд заагдсан зохицуулалтын бус аж ахуйн нэгж, хуулийн этгээдүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хуулийн хэрэгжилтийг хангуулах үүргийг Хорооны үндсэн чиг үүргээс гадна нэмэлтээр хүлээх болсон;
- УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”, ЗГ-ын 2016 оны 208 тогтоолоор баталсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө”-нд Хорооноос хийж хэрэгжүүлэхээр 30 гаруй чиглэлээр холбогдох ажлууд тусгагдсан зэрэг болно;
- Үйл ажиллагааны чиг үүрэг, зах зээлийн хамрах хүрээ нэмэгдсээр байтал зардлын төсөв нэмэгдээгүй, сүүлийн жил тутам 15–20 хувиар буурснаар зарим тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, Хорооны чиг үүргийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй нөхцөл үүсэж байна;
- Орон нутагт гарсан зөрчил дутагдлыг газар дээр нь очиж хийх үзлэг, хяналт шалгалт явуулах ажил сүүлийн 3 жил хийгдээгүй;
- Зайны хяналтын “Фин-А” системийн сайжруулалт нь хэрэглээний шаардлагыг хангахгүй болсон, тусгай зөвшөөрөл олгох үйл явцыг бүрэн цахимжуулах шаардлагата;
- Тагнуулын ерөнхий газрын дүгнэлтээр санхүүгийн зах зээлийн мэдээ, мэдээллийн аюулгүй байдлын түвшин “Маш эрсдэлтэй” гэж дүгнэгдсэн нь мэдээллийн кибер аюулгүй байдлын хамгаалалтыг сайжруулах шаардлага бий болсон;
- Хорооны үндсэн хөрөнгийн 40 гаруй хувь нь ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, техник технологийн шаардлага хангахгүй компьютер тоног төхөөрөмжөөр ажилтан, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэж байгаа зэрэг асуудлуудыг шийдвэрлэхэд Хорооны төсвийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

## ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР ТӨЛӨВЛӨЖ БҮЙ АЖЛУУД

Монгол Улсын санхүүгийн салбарт банк давамгайлсан өрөөсгөл бүтцийг өөрчлөх санхүүгийн бусад салбарын өрсөлдөх чадварыг бий болгох, хүртээмжийг нэмэгдүүлэх хямд эх үүсвэр татан төвлөрүүлэх боломжийг бий болгохыг дэмжиж олон тулгуурт санхүүгийн зах зээлийн шинэ тогтолцоог бий болгох бодлого боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх нь чухал зорилт болоод байна.

Энэхүү зорилтын хүрээнд УИХ-аас батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэл”, “Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” зэрэг төрийн бодлогын баримт бичгүүдэд салбарын чиглэлээр тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд анхаарлаа хандуулан ажиллах болно

Хороо 2006 онд байгуулагдсанаас хойш зохицуулалт, хяналтад хамаарах санхүүгийн салбар, эрхлэх асуудлын хүрээ улам бүр нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар Хороо үйл ажиллагааг шууд зохицуулсан 20 гаруй хууль,

түүнийг дагаж батлагдсан 200 гаруй журам, заавар, аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Хорооны зохицуулалт, хяналтад 2017 байгууллага, хуулийн этгээд, 3,741 иргэн хамаарч байна. Банкнаас бусад санхүүгийн салбарын хяналт зохицуулалтыг үр дүнтэй, зохистой хэрэгжүүлэхийн тулд гадаад орнуудын ижил төстэй чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, туршлагыг судлах улмаар, Хорооны бүтэц зохион байгуулалт, эрх хэмжээ, чиг үүргийг улам бүр боловсронгуй болгох, оновчтой тодорхойлох шаардлага байсаар байна. Ялангуяа хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд Хорооны эрх хэмжээг өргөжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Иймд Хорооны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн боловсруулж батлуулахаар ажиллана. Мөн дээрх шаардлагын улмаас Хорооны бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгож зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, хуульд заасан чиг үүргээ зохистой хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авна.



Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбаруудын хяналт, зохицуулалтыг үр дүнтэй, зохистой хэрэгжүүлэх нэг нөхцөл бол эдгээр санхүүгийн салбаруудад эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэвтрүүлэх явдал юм. Эрсдэлд суурилсан хяналт, шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр зохицуулалтын салбар бүрээр судалгаа хийнэ.

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц, арилжаа, төлбөр тооцооны үйл ажиллагааг боловсронгуй болгох, энэ чиглэлд үүсээд байгаа тулгамдсан асуудлыг шат дараатайгаар шийдвэрлэх арга хэмжээг авна. Хөрөнгийн зах зээлд мэргэжлийн, институциональ хөрөнгө оруулагчдыг бий болгох, хөрөнгө оруулалтын сангууд бий болохыг бодлогоор дэмжиж ажиллана.

Урт хугацааны даатгал, хүртээмжтэй даатгалын тогтолцоог хөгжүүлэн хувийн тэтгэврийн санг өргөжүүлэх үүднээс зохицуулалтын орчныг шинээр бий болгох судалгаа хийж, санал боловсруулна. Ипотекийн зээлдэгчийн даатгалын шинэ бүтээгдэхүүний зохицуулалтын орчинг бүрдүүлж даатгуулагчдад чиглэсэн санхүүгийн боловсролын хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл авах явдлыг хөнгөвчлөх, шуурхай болгох, энэ салбар өсөж томрон эдийн засгийн өсөлтөд нөлөө үзүүлэхүйц болгох, улмаар банкны салбартай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг эцэслэн боловсруулж батлуулах арга хэмжээ авна.

ХЗХ-ны салбарыг 2017–2021 онд хөгжүүлэх дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийг Хорооны үйл ажиллагааны стратегитай уялдуулан боловсруулж, батлах, хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журамд нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулах, төсөл, хөтөлбөрүүдэд үнэлгээ өгөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

Хорооны стратеги төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх ажлын хүрээг тоймлон харуулбал дараах байдалтай байна.

- Хууль, эрх зүйн зохицуулалт, хяналтын орчныг сайжруулах;
- Зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- Мэргэжлийн оролцогчдыг чадавхжуулах;
- Шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлж, санхүүгийн хүртээмжийг сайжруулах;
- Санхүүгийн үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах;
- Олон улсын байгууллагуудтай ажиллах;

Хороо нь туршлагатай, чадварлаг, мэргэжлийн боловсон хүчин, баг хамт олноороо УИХ, ЗГ, Сангийн яам, Монголбанк болон гадаад, дотоод бүх талын хамтын ажиллагаагаа өргөжүүлэн “Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, стандартад нийцсэн тогтвортой үйл ажиллагаа бүхий санхүүгийн салбарыг хөгжүүлэх” эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагаагаа явуулах болно.

